

Өмнөтгөл

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөлд газрын харилцааны эрх зүйн орчны шинэтгэлийн хүрээнд гарсан Газрын тухай багц хуулиудаар газрын харилцааны зохицуулалт улам бүр боловсронгуй болж газрын үр өгөөжийг зөвхөн ашиглах бус, хамгаалах, нөхөн сэргээх, газрын харилцаанд оролцогчдод тэгш шударга байдлыг хангасан эрх, үүргийн харьцааг тэнцвэржүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн юм.

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон сав шимийн ертөнц учраас түүний ашиглалтын цар хүрээ өөрийнх нь унаган чадавхиар тодорхойлогддог. Ийм практик Монгол Улсад нилээд шинэлэг асуудал боловч дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үндэс болжээ. Үүний үзэл баримтлал нь газар болоод газраас үндэстэй байгалийн баялгийг зөв зохистой ашиглан нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх зарчимд тулгуурласан байдаг ба монгол оронд хэрэгжүүлэх үндсэн механизм нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан хөгжлийн бодлого юм.

Монгол улсын газрын тухай хуулийн 24.1-р зүйлд Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн гэж заасан байдаг бөгөөд 24.2-т Газар зохион байгуулалтын арга хэмжээг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ гэж заасны дагуу газрын мэргэжлийн байгууллага болох “Геоботаник”ХХК нь хийж гүйцэтгэсэн.

Мөн хуулийн 25.3-т Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн баримт бичгийг 2016-2030он хүртэл хэрэгжихээр боловсруулсан болно.

Уг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлтийн ажлыг МУ-н Газрын тухай хууль, Газрын кадастрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хууль, Барилга, хот байгуулалтын Сайдын 2007 оны 156-р тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах арга зүйн заавар”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

I. ХАА-Н ГАЗРЫН АШИГЛАЛТЫН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

I.1. Тариалангийн газрын төлөвлөлт

I.1.1. Газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамж, шаардагдах тариалангийн газрын хэмжээ

Хөдөө аж ахуйн салбарын стратегийн ач холбогдол бүхий хүнсний гол бүтээгдэхүүнүүдийн нэг нь газар тариалангийн салбараас авч буй үр тариа, төмс, хүнсний ногоо юм. 1990 онд улс орон зах зээлийн харилцаанд шилжиж улсын хэмжээгээр газар тариалангийн үйлдвэрлэл уналтад ороод байсан ба Монгол Улсын Засгийн газраас 2008 оны “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр, “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд 2012 оны байдлаар 2007 онтой харьцуулбал нийт тариалах талбай 180 мян.га- аар, хураан авах буудай 4 дахин, төмс 1.7 дахин, хүнсний ногоо 1.3 дахин нэмэгдсэн байна. Тус хөтөлбөрт тариалангийн нийт эргэлтийн талбайн хэмжээг 600.0 мян.га-д хүргэх, 2008 онд 50.0 мян.га, 2009 онд 80.0 мян.га, 2010 онд 100.0 мян.га атаршсан талбайг үйлдвэрлэлд буцаан ашиглах, ганд тэсвэртэй, арвин ургацтай, усалгаатай болон усалгаагүй нөхцөлд тохирох зусах буудайн сортын үрийг импортлон үржүүлэх, сэлгээнд хөх тариа, арвай, хошуу будаа, царгас, эрдэнэ шиш, вандуй зэргийг ашиглаж, үр тариа, тэжээл үйлдвэрлэл эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлэх, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 54.2 мян.га-д хүргэх, арван мян.га талбай услах хүчин чадалтай услалтын хуучин системийг сэргээн засварлах, 22.0 мян.га талбай бүхий услалтын системийг шинээр ашиглалтад оруулах, 15 сая шоо метр усны нөөц бүхий усан сан байгуулах зэрэг олон арга хэмжээнүүд тусгагдсан ба хүн амын хэрэгцээг 100% хангах зорилтыг тавьсан байна.

Дархан-Уул аймгийн хувьд 2014 оны жилийн эцсийн статистикийн газрын мэдээгээр 3948тн төмс, 15113тн үр тариа, 14840тн хүнсний ногоо хураан авсан ба энэ нь одоогийн аймгийн нийт хүн амын хэрэгцээг төмснөөс бусад үзүүлэлтээр бүрэн хангаж байна. /үр тариа 127,6%, Төмс 79,3%, Хүнсний ногоо 208,83%/ Төлөвлөлтийн үе шатуудад /2020, 2025, 2028 онууд/ өсөн нэмэгдэх хүн амыг тооцоолон /статистикийн мэдээнд үндэслэн/ шаардагдах бүтээгдэхүүний хэрэгцээг дор үзүүлэв.

Төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын өсөлтийн тооцоолол

/Үндэсний статистикийн хорооны мэдээ/

Хүснэгт №1

	2030 он	2025 он	2020 он
Улсын дүн	3,576,877	3,377,503	3,151,086
Дархан-Уул	104,426	102,125	99,058

Газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээ

Хүснэгт№2

Он	Төрөл	Хэрэгцээ	Хүн ам	Хэрэгцээ /тн/
2020	Төмс	Улсын хэмжээнд	3,151,086	161,020.49
		Аймгийн хэмжээнд	99,058	5,061.86
	Үр тариа	Улсын хэмжээнд	3,151,086	383,382.13
		Аймгийн хэмжээнд	99,058	12,052.06
	Хүнсний ногоо	Улсын хэмжээнд	3,151,086	230,029.28
		Аймгийн хэмжээнд	99,058	7,231.23
2025	Төмс	Улсын хэмжээнд	3,377,503	172,590.40
		Аймгийн хэмжээнд	102,125	5,218.59
	Үр тариа	Улсын хэмжээнд	3,377,503	410,929.53
		Аймгийн хэмжээнд	102,125	12,425.21
	Хүнсний ногоо	Улсын хэмжээнд	3,377,503	246,557.72
		Аймгийн хэмжээнд	102,125	7,455.13
2030	Төмс	Улсын хэмжээнд	3,576,877	182,778.41
		Аймгийн хэмжээнд	104,426	5,336.17
	Үр тариа	Улсын хэмжээнд	3,576,877	435,186.70
		Аймгийн хэмжээнд	104,426	12,705.16
	Хүнсний ногоо	Улсын хэмжээнд	3,576,877	261,112.02
		Аймгийн хэмжээнд	104,426	7,623.10

Тус хүн амын шаардагдах хүнсний хэрэгцээг тооцоолохдоо Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан нэг хүнд шаардагдах жилийн дундаж хүнсний хэрэглээний нормыг баримталсан. /хүснэгт№3/

Нэг хүний жилийн дундаж хүнсний хэрэгцээ (кг/хүн) Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалын тавдугаар хавсралт

Хүснэгт№3

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр эсвэл мл)	Шимт бодисууд (гр)							Илчлэг (ккал)
			Уураг	Үүнээс		Тос	Үүнээс		Нүүрс ус	
				Амьтны	Ургамлын		Амьтны	Ургамлын		
1	Мах, махан бүтээгдэхүүн	150	28	28	0	19	19	0	0	281
2	Сүү	200	10	10	0	9	9	0	10	160
3	Тараг, аарц	295	8	8	0	9	9	0	12	166
4	Гурил	100	9	0	9	1	0	1	70	325
5	Гурилан бүтээгдэхүүн	220	12	0	12	2	0	2	95	452
6	Будаа	78	9	0	9	0	0	0	57	269
7	Сахар, чихрийн зүйл	23	0	0	0	0	0	0	23	92
8	Төмс	140	3	0	3	0	0	0	28	123
9	Хүнсний ногоо	200	2	0	2	0	0	0	5	28
10	Буурцагт ургамал (вандуй, шош)	90	17	0	17	2	0	2	45	265
11	Жимс	180	1	0	1	0	0	0	20	84
12	Өндөг	19	2	2	0	2	2	0	0	30
13	Ургамлын тос	25	0	0	0	25	0	25	0	225
Бүгд		1720	101	48	53	69	39	30	365	2500
Үндсэн шимт бодисын илчлэг			404	192	212	621	351	270	1460	
Үндсэн шимт бодисын илчлэгийннийт илчлэгт эзлэх хувь			16			25			59	

Тайлбар:

- Илчлэгийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг харьцангуй эрүүл монгол хүний хүнсний бүтээгдэхүүний хоногийн дундаж хэрэглээн дээрүндэслэн тогтоов.

Төлөвлөлтийн үе шатны жилүүдэд хүн ам өсөхийн хэрээр газар тариалангийн хэрэгцээт бүтээгдэхүүн нэмэгдэж байгаа бөгөөд Дархан-Уул аймаг нь Монгол улсын газар тариалангийн гол бүс нутагт багтдаг ба үр тарианы 3%, төмсний 4,1%, хүнсний ногооны 14,5%-ийг хангадаг. Цаашид төлөвлөлтийн үе шатуудад нэмэгдүүлэх шаардлагатай бүтээгдэхүүний хэмжээг тооцоолоход төмсний үйлдвэрлэлээр аймгийн хүн амын хэрэгцээг 100% хангах, бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг улсын хэмжээнд эзлэх хувийг багасгахгүй байхаар тооцоолон, шаардагдах газрын хэмжээг гаргав.

*Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шаардлагатай
тариалангийн газрын тооцоо*

Хүснэгт№4

Он	Төрөл	Шаардлагатай нийт үйлдвэрлэл /тн/	Жилд тариалалт хийх шаардлагатай талбай /га/	Шаардлагатай нийт эргэлтийн талбай /төрлөөр. га/
2020	Төмс	5,061.86	428.97	857.94
2025		5,218.59	442.25	884.51
2030		5,336.17	452.22	904.44
2020	Хүнсний ногоо	34504.39	2,875.37	5,750.73
2025		36983.66	3,081.97	6,163.94
2030		39166.8	3,263.90	6,527.80
2020	Үр тариа	11501.46	8,847.28	26,541.84
2025		12327.89	12327.89	36,983.66
2030		13055.6	10,042.77	30,128.31

Тус тооцооллыг хийхэд гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээт талбайг тооцсон бөгөөд бусад бүтээгдэхүүнийг ээлжлэн тариалалтын явцад үйлдвэрлэл явуулах боломжтой гэж үзсэн болно.

Одоогоор Дархан-Уул аймгийн тариалангийн газрын хэмжээ 34814,84га бөгөөд цаашид 2030 он гэхэд 37560,0га газар хэрэгцээтэй болох юм. Иймд 2030 он гэхэд 2750га-р нэмэгдүүлэх шаардлагатай. Тус тооцооллыг хийхэд ургацын хэмжээг 2010-2014 оны улсын дундажаар тооцоолсон ба төмс хүнсний ногооны талбайн хэмжээг 2 ээлжит тариалалтын нөхцөлд, үр тарианы талбайг 3 ээлжит ээлжлэн тариалалтын нөхцлөөр тооцоолов.

Тариалангийн газрын хэмжээг нэмэгдүүлэх боломж бүхий газруудыг тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан тогтоож дор үзүүлэв.

I.1.2. Газар тариалангийн салбарын SWOT шинжилгээ

Газар тариалангийн салбарын хөгжилд өнөөгийн байдлаар нөлөөлж нийт хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлсон.

Үр тарианы үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт №5

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл(O)	Таагүй нөхцөл (Т)
1. Нутагшсан сорт	1. Тариаланчдын санхүүгийн чадавхи	1. Зах зээлийн эрэлт	1. Хөрсний үржил шимийн хангамж муудсан
2. Механикжилт	2. Технологи хоцрогдсон, нөөцөд халтай	2. Засгийн газрын дэмжлэг	2. Байгаль цаг уурын нөхцөлөөс хамааралтай
3. Агротехник боловсрогдсон	3. Үйлдвэрлэл тогтвортой бус	3. Тариалангийн газрын нөөц	3. Тариалангийн газрын ихэнх нь салхины элэгдэлд өртөх магадлалтай болон дунд зэрэг элэгдсэн
4. Усалгаатай тариалан эрхлэх боломжтой	4. Үрийн зах зээл, чанар, хангамж	4. Иргэн аж ахуйн нэгжийн тариалан эрхлэх сонирхол	
	5. Техник тоног төхөөрөмжүүд муудсан		

Хүнсний ногооны үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт №6

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл(O)	Таагүй нөхцөл (Т)
1. Нутагшсан сорт	1. Тариаланчдын санхүүгийн чадавхи	1. Зах зээлийн эрэлт	1. Хөрсний үржил шимийн доройтол
2. Механикжилт	2. Технологи хоцрогдсон, нөөцөд халтай	2. Засгийн газрын дэмжлэг	2. Байгаль цаг уурын нөхцөлөөс хамааралтай
3. Агротехник боловсрогдсон	3. Үйлдвэрлэл тогтвортой бус	3. Тариалангийн газрын нөөц	3. Нөөшлөх, хадгалах байгууламж муутай
4. Усалгаатай тариалан эрхлэх боломжтой	4. Үрийн зах зээл, чанар, хангамж	4. Тариалан эрхлэх сонирхол	4. Хадгалалтаас үүдэлтэй хаягдал
	5. Зарим нэр төрлийн бүтээгдэхүүн хадгалалт даах чадвар		5. Услалтын системийн усны нөөц хомсдолт

Төмсний үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт №7

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл(O)	Таагүй нөхцөл (Т)
1. Нутагшсан сорт	1. Тариаланчдын санхүүгийн чадавхи	1. Зах зээлийн эрэлт	1. Хөрсний үржил шимийн доройтол
2. Механикжилт	2. Технологи хоцрогдсон, нөөцөд халтай	2. Засгийн газрын дэмжлэг	2. Байгаль цаг уурын нөхцөлөөс хамааралтай
3. Агротехник боловсрогдсон	3. Үйлдвэрлэл тогтвортой бус	3. Тариалангийн нөөц	3. Нөөшлөх, хадгалах байгууламж муутай
4. Усалгаатай тариалан эрхлэх боломжтой	4. Үрийн зах зээл, чанар, хангамж	4. Тариалан эрхлэх сонирхол	4. Хадгалалтаас үүдэлтэй хаягдал
			5. Услалтын системийн усны нөөц хомсдолт

1.1.3. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд Газрын харилцаа геодези зураг зүйн газрын захиалгаар “Инжгеотех”ХХК-ийн боловсруулсан арга зүйн дагуу хийж гүйцэтгэв.

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хүснэгт №8

Үнэлэх үндсэн үзүүлэлт	Үнэлэх дэд үзүүлэлт	Хэмжих нэгж	Үнэлгээ баллаар				
			Нэн тохиромжтой (5 балл)	Тохиромжтой (4 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (3 балл)	Тохиромжгүй (2 балл)	Нэн Тохиромжгүй (1 балл)
Газрын гадаргын үнэлгээ							
Газрын гадарга	Гадаргын налуу	Градус	0-2	2-4	4-6	6-12	12-оос их
	Зүг зовхис	Градус	Тэгш гадарга, У (157.5-202.5)	Бу. Б (202.5-292.5)	3. ЗУ (67.5-157.5)	3Х, БХ (22.5-67.5) (292.5-337.5)	Х (0-22.5)
	Гадаргын өндөршил	Метр д.т.д	1000-аас бага	1000-1500	1 500-2000	2000-3500	3500-аас ил
Гидрологийн үнэлгээ							
Гидрологи	Голын сүлжээний нягтшил	км/км ²	0.4-өөс д)эш	0.2-0.4	0.1-0.2	0,05-0.1	0,05-зэс доош
	Цэвдэг чулуулаг		Цэвдэггүй	Тохиолдлын болон енжмөл тархалттай	Элбэг алаг цоог	Тасалданги тархалттай	Үргэлжилсэн тархалттай
Хөрсний хими-физик шинж чанарын үнэлгээ							
Хөрс	Хөрсний хэвшинж (Доктор Б.Энхмаагийн тодорхойлсон нийт 58 хэв шинж, дэд хэв шинжийн хөрсний дэлгэрэнгүй үнэлгээг хийсэн бөгөөд зарим бага тархалттай дэд хэв шинжүүдийг нэгтгэж жинлэгдсэн дунджийн аргаар 27 болгосныг үнэлгээнд авч ашиглана. Тухайлбал, голын хөндийн хөрс гэсэн бүлэгт аллювийн ердийн ширэгт, үелсэн ширэгт, аллювийн нугын сул хөгжилтэй, хээршмэл, хэвийн, аллювийн нуга намгийн дэд хэв шинжийн хөрсийг хамруулсан байна.)		- Тал хээрийн хар шороон хөрс -Голын хөндийн хөрс -Нугархаг хээрийн хар хүрэн хөрс -Тал хээрийн хар хүрэн, хүрэн хөрс -Уулын ойт хээрийн хар хүрэн хөрс -Уулын ойт хээрийн нугын хүрэн хөрс -Уулын ойт хээрийн хар шороон хөрс	-Уулын ойн бараан хөрс -Өндөр уулын нугын бараан хөрс -Өндөр уулын хээрийн бараан хөрс -Уулын тайгын ухаа шороон ширэгт хөрс	-Уулын тайгын ухаа шороон цэвдэгт хөрс -Дов толгодын хүрэн шороон хөрс -Уулын тундрын ухаа шороон хөрс -Уулын хээрийн хүрэн шороон хөрс -Уулын нарсан ойн элсэн хүрэн хөрс -Тал хээрийн цайвар хүрэн хөрс	-Цөлөрхөг хээрийн далд глейрхэг бор хөрс -Бүс дундын хужирлаг мараалаг хөрс -Цөлөрхөг хээрийн бор хүрэн хөрс -Уулын цөлөрхөг хээрийн бор хүрэн хөрс	-Уулын цөлийн бор саарал хөрс -Цөлийн гөлтгөнөт бор саарал хөрс -Цөлийн бор саарал хөрс -Цөлийн элсэн хучаас бүхий бор саарал хөрс -Цөлөрхөг хээрийн элсэн бор хөрс -Шал хөрс
	Хөрсний ялзмаг агууламж	(%)	4<	3-3.9	2-2.9	1-1.9	0-0.9
	Хөрсний ялзмагт үеийн зузаан	(см)	20.1	15.1-20	10.1-15	5.1-10	<5
	Хөрсний механик бүрэлдэхүүн	-	Хенген шавранцар (21-30). Элсэнцэр(10-20)	Дунд шавраниар (31-45)	Элс(<10)	Хүнд шавранцар (45-60)	Шавар<>60)

	Хөрсний урвалын орчин	(рН)	6.5-7.0	7.1-7.5 6.1-6.5	7.6-8 5.6-6.0	8.5-9 5.1-5.5	9-өөс их 5-аас бага
	Хөдөлгөөнт фосфорын агууламж	(%)	0,46-аас их	0.31-0,45	0,16-0,30	0,11-0,15	0,10-аас бага
	Хөдөлгөөнт калийн агууламж	(мгэкв/100 г)	10,3-аас их	7,7-10,2	5,1-7,7	2.6-5.1	2.6-аас бага
	Хөрсний ус нэвчүүлэх чадвар (Natalie Hunt, Bob Gilkes нар, 1992)	мм/ц	Хөнгөн шавранцар (30-40)	Дунд шавранцар (20-30)	Элс (40-50)	Хүнд шавранцар (20-10)	Шавар (5-10)
Уур амьсгалын үнэлгээ							
Үнэлэх үндсэн үзүүлэлт	Үнэлэх дэд үзүүлэлт	Хэмжих нэгж	Үнэлгээ баллаар				
			Нэн тохиромжтой (5 балл)	Тохиромжтой (4 балл)	Хязгаарлагд мал тохиромжтой (3 балл)	Тохиромжгүй (2 балл)	Нэн Тохиромжгүй (1 балл)
Уур амьсгал	Ургамлын дулаан хангамжийн нөхцөл (Т) 7-р сарын дундаж температур	(Градус)	22-23	19-22	15-19	13-15	13-аас бага
	Ургамлын чийгхангамж	(М)	55-80	30-55	10-30	80-100	10-аас бага
	Хур тунадас	(мм)	250-350	150-250	50-150	350-аас их	50-аас бага




Зураг №1. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн зургууд

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хүснэгт №9

Үнэлэх үзүүлэлт	Хэмжих нэгж	Үнэлгээ баллаар				
		Нэн тохиромжтой (5 балл)	Тохиромжтой (4 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (3 балл)	Тохиромжгүй (2 балл)	Нэн Тохиромжгүй (1 балл)
Гадаргын налуу	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	28.2	38.8	21.7	11.2	0.1
Өндөржилт		68.1	31.8	0.1		
Зүг зовхис		9.8	31.0	17.0	36.5	5.7
Цэвдэг			100			
Хөрс		75.4	18.6	5.2	0.5	0.3
Ургамлын дулаан хангамж				69.5	30.2	0.3
Ургамлын чийг хангамж		69.5	30.2	0.3		
Хур тунадас		98.2			1.8	

Дээрхи хүчин зүйлүүдийг жигнэсэн дундажыг тооцоолон нэгтгэх замаар тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний нэгтгэл зургийг боловсруулав.




Зураг №2. Хүчин зүйлүүдийн жигнэсэн дундажын матриц

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний нэгтгэл

Хүснэгт №10


	Үнэлгээ баллаар				
	Нэн тохиромжтой (5 балл)	Тохиромжтой (4 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (3 балл)	Тохиромжгүй (2 балл)	Нэн Тохиромжгүй (1 балл)
Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь		56.8	42.1	1.1	
Одоогийн тариалангийн газартай давхацсан байдал/га/		30649.0	4181.0		

Дээрхи тохиромжтой байдлын үнэлгээг аймгийн нийт нутаг дэвсгэрээр тооцоолсон бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий газар, ой бүхий газар, ой бүхий газар гэх мэт хязгаарлагч хүчин зүйл бүхий газруудыг хасаагүй дүн юм.



Зураг №3. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний нэгдсэн зураг

Одоогийн ашиглаж буй тариалангийн талбайг уг тохиромжтой байдлын үнэлгээтэй давхцуулан үзэхэд талбайн ихэнх хэсэг 4 балл буюу тохиромжтой ангилалд, зарим талбайн зах хэсэг болон Хонгор сумын нутаг дахь Загт өндөр уулын хойт хэсгийн зарим талбай хязгаарлагдмал тохиромжтой буюу 3баллын үнэлгээ авсан байна.



Зураг №4. Одоогийн ашиглаж буй тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

1.1.4. Тариалангийн газрын ашиглалт хамгаалалтын сайжруулах, арга хэмжээ

Эрдэмтдийн судалгаагаар манай орны тариалангийн хүрэн хөрсний үржил шим нь ашиглалтын явцад ихээхэн доройтсон байна. Үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн хувьд нийт 579.3 мянган га талбайн 70.7%-ийг 2.5 хувиас бага, 15.1%-ийг 3 хувийн ялзмагтай хөрсээлж байна. Газрын бодлогын хүрээлэнгийн судалгаанд нийт (1992)1206.4 мян.га талбай хамрагдсанаас 561.5 мян.га нь элэгдсэн, үүний дотор 12.9 % нь хүчтэй элэгдсэн байсан бол УГТСЭШ-ний хүрээлэнгийн судалгаагаар (2010) нийт 579.3 мян. га хамрагдсанаас бүгд элэгдсэн ба 60.6 % нь хүчтэй элэгдсэн байгаа гэсэн судлаачдын дүнгээс үзэхэд сүүлийн 20 орчим жилийн хугацаан дахь хөрсний үржил шимийн бууралт нь гамшгийн хэмжээнд хүрч болохоор байна.

Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хөрс хамгаалах талын мэдлэг , санхүүгийн боломж хязгаарлагдмал байгаагаас бордоо хэрэглэх нь бага байгаа юм. Бичиг баримтан дээрээ олон эзэнтэй тэд талбайг булаацалддаг боловч үржил шимийг хамгаалах эзэн алга. Нийт талбай тарилтанд бэлтгэгдэж олон дахин боловсруулагдаад ургамлан бүрхэвчгүй болсон байдаг 4 ба 5 саруудад салхины хурд эрс нэмэгддэг нь байгалийн ба хүний үйл ажиллагаа хавсран хөрс хийсэх, элэгдэлд нэрвэгдэх процессыг эрчимжүүлдэг.

Ийм нөхцөлд бид тариалангийн систем, юуны өмнө сэлгээг шинэчлэх эргэлтийн хугацаан дахь ургамлын нэр төрлийг олшруулах, хөрсний үржил шимийн түвшинд хяналт тавих, органик ба эрдэс бордоо хэрэглэх, хөрсийг хөмрүүлэгчгүй анжисаар хагалах, хөрс элдэншүүлэлтийг цомхотгох шаардлагатай байна. Мөн тариалангийн талбайг ус салхины элэгдэлээс хамгаалах арга ойн зурвас байгуулах арга хэмжээнд нэлээд анхаарал хандуулах шаардлагатай байгаа ба уг ажил нь хөрөнгө оруулалт ихээр шаардах боловч нэгэнт бий болсон нөхцөлд олон жилийн хугацаанд талбайг хамгаалдаг үр дүнтэй арга юм. Сүүлийн үед уринш-буудай гэсэн 2 талбайт сэлгээг мөрдөж байгаа ба хөмрүүлж хагалах систем нь хөрс элэгдэх процессыг эрчимжүүлж байна. Ийм учраас хөрс хамгаалах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Ойн зурвас байгуулах

Ойн мелиорац гэдэг нь байгаль уур амьсгалын нөхцөлийг хүмүүсийн амьдрал үйлдвэрлэлд ашигтайгаар өөрчлөх зорилгоор ойг тарьж ургуулахыг хэлнэ. Ойн мелиорацийн ажил нь таримал ойгоос модлог болон бусад бүтээгдэхүүнийг ашиглах зорилгоор бус харин түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг ашиглах чиглэлээр хийгддэгээрээ ойжуулалтын ажлаас ялгарна.

Ойн зурвас нь салхины хүчийг бууруулж хөрс салхинд элэгдэж, эвдрэхээс хамгаалахад онцгой ач холбогдолтой. Ойн зурвасын салхины хамгаалах үйлчилгээ нь зурвасын өндөр, бүтцээс шалтгаалахаас гадна салхины хурд, ойн зурвасанд салхины чиглэлийн үүсгэх өнцөг, хөрсний гадаргуугийн температурын

нөхцөл зэргээс шалтгаалдаг. Хамгаалах үйлчилгээ нь ойн зурвасын бүтцээс хамаарна. Хээр, ойт хээрийн бүсэд битүү биш ойн зурвас илүү ач холбогдолтой.

Үүнд: Ойт хээрт 3 эгнээ, хээрт 7 эгнээ байхаас гадна цас тогтоох зорилгоор салхин талд нь намхан бут сөөг тарина. Ойн зурвасыг юуны өмнө салхины гол чиглэлд перпендукуляр байгуулна. Энэ тохиолдолд салхины хамгаалах үйлчилгээ хамгийн их байна. Салхины чиглэл ойн зурвасын чиглэл хоёрын хоорондох өнцөг багасах тутам хамгаалах үйлчилгээний зай багасдаг. Манай орны ойт хээрийн бүсэд ойн зурвас байгуулахад хар мод, нарс, хус, улиас, хайлаас тарьвал зохимжтой. Талбай хамгаалах ойн зурвас нь хөрсийг салхинаас хамгаалах, чийгийн тохиромжтой нөхцөл бүрдүүлэхэд чухал арга хэмжээ болдог.

Талбайд гуурс үлдээх болон сүрлэн хучаас хийх

Тариалангийн талбай дахь гуурс, сүрэл нь хөрсний гадаргуутай шүргэх салхины хүчийг эрс бууруулдагаараа үлэмж ач холбогдолтой. Нэгж талбай дахь гуурсны тоо хичнээн олон байвал хөрс хамгаалах чадал нь төдий чинээ их байдаг. Тариалангийн талбайд тоололт хийж үзэхэд нэг ам метр газарт босоо гуурс 180-300 орчим байхад шороо хийсэх тохиолдол ер ажиглагддаггүй. Ингэхлээр нэг талбайд 180 орчим ширхэг босоо гуурс ногдож байгаа нөхцөлд хөрс салхины хөнөөлд нэрвэгдэхгүй гэж үзэж болмоор санагддаг. Гэтэл үнэн хэрэг дээрээ тийм биш бөгөөд энд хөрсний бүхэлшил, тэдний хоорондох барьцалдах хүчний нөлөө бас байдаг. Тэгэхлээр хөрсийг элэгдлээс хамгаалахад нэгж талбай дахь гуурсний тоо олон, хөрсний өнгөн хэсэг дэхь ширхэгүүдийн хэмжээ том бөгөөд өөр хоорондоо барьцалдсан байх явдал чухал.

Хөрсний элэгдэл, эвдрэлтэй тэмцэхэд бордоог хэрэглэх

Хөрсийг хамгаалах, бордоог хэрэглэх асуудлууд өөр хоорондоо нягт холбоотой юм. Өөрөөр хэлбэл бордоог хэдий сайн хэрэглэх нь хөрсний бүтцийг төдий чинээ сайжруулж түүнийг ус ба салхины элэгдэл, эвдрэлээс улам сайн хамгаална. Бордоо хэрэглэсэн хөрснөөс ургамал шим тэжээлийн бодисыг сайн авч улмаар үндэсний хүчирхэг системтэй, шигүү сайн ургаж цаг зуурын бороо, шуурганаас хөрсийг найдвартай сайн хамгаалдаг. Ялангуяа орон нутгийн үнэт бордоо болох бууц, шим бордоо нь сайн нөлөөлнө. Амьд ахуйн гаралт бордоо нь хөрсний бүтцийг сайжруулж, бичил биетний үйл ажиллагааг ихэсгэж ургамлын ургацыг нэмэгдүүлсэнээр хөрсийг усанд идэгдэхээс сайн хамгаалдаг байна.

Зурваслан тарих арга


Уринш, өргөн мөрөөр таригддаг таримлыг зун хэд хэдэн удаа боловсруулалт хийх тул гуурс, ургамлын үлдэгдлийн ихэнх нь булагдаж ийм талбай ямарч хучлагагүй удаан хугацаагаар байхад хүрдэг. Хэрэв түүнийг салхинаас хамгаалах арга хэмжээ эс авбал салхины элэгдэл, эвдрэлд ордог.

Хөрсийг хавж боловсруулахын сацуу уринш өргөн мөрт ургамал тарьсан талбайг үр тарианы юмуу олон наст өвсний тариалангийн хоорондуур түүнтэй салаавчлан нарийн зурвасаар байрлуулахыг зурваслан тарих арга гэдэг. Зурваслан тарих арга дараах зарчимд үндэслэгдэнэ.

- Салхины урсгал нь тодорхой нэг зайд шороогоор ханаж түүнээс цааш шороог нэмж хийсгэдэггүй.
- Салхины урсгалд орших шорооны дээд хэмжээ бүх төрлийн хөрсөнд адилхан байдаг.
- Салхины урсгалд шороогоор ханах зайн урт нь хөрсний механик бүрэлдэхүүн, бүтцийн байдлаас хамаардаг.

Хэрэв салхины урсгалаар хийсч байгаа шорооны хэмжээ нь байж болох шорооны хэмжээнээс хэтрэх зайд ямар нэгэн механик саад тавивал тэр нь цаашаа хөгжиж шороон шуурга болохоос хамгаалдаг. Зурвасыг салхины гол чиглэлд нь перпендикуляр байх шаардлагыг заавал биелүүлэх явдал чухал. Эс тэгвэл зурваслан тарих арга хөрс хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй.

Дархан-Уул аймгийн хувьд тариалангийн талбайнуудын 0.5% нь элэгдэл, эвдрэлд сулавтар орж болзошгүй, 37.2% нь дунд зэрэг орж болзошгүй, 26.9% хувь нь хүчтэй орж болзошгүй байна. Мөн нийт тариалангийн талбайнуудын 19.3% нь сулавтар, 12.5% нь дунд зэрэг, 3.7% нь хүчтэй ус, салхины элэгдэл, эвдрэлд тус тус орсон байна.



Зураг №5. Дархан-Уул аймгийн тариалангийн газруудын элэгдэл эвдрэлийн зэрэглэл

Тариалангийн талбайн ашиглалт хамгаалалтын бусад арга хэмжээний зөвлөмж

Таримлын сэлгээ

Буудайн тариаланг өргөжүүлэх явцад сэлгэж тариалах хуулиа орхигдуулж болохгүй бөгөөд буудайнаас гадна хүнсний арвай, хар будаа, хөх тариа, сагаг, эрдэнэшиш болон малын тэжээлийн үет, буурцагт ургамлыг тариалах замаар таримлын бүтцэд өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

Нэг төрлийн таримал дагнан тариалснаас агроэкоосистемийг бүхэлд нь тогтворгүй болгож биоценозийн ядууралд хүргэн улмаар эрсдэлийг дагуулж байна. Үр тариа, тэжээл үйлдвэрлэлийн бүтэц, байршлыг зөв тогтоож, газар тариалан, мал аж ахуйн салбарын уялдаа, бие биеэ нөхөх органик холбоог хангахгүйгээр энэ хоёр салбарын тэгш хөгжлийг зэрэг хангаж чадахгүй юм.

Бэлчээр нутаг доройтож байгаа энэ цаг үед буудайн дараачийн ээлжийг таримал тэжээлд зориулах асуудлыг ч бодож төлөвлөх хэрэгтэй. Ялангуяа газар тариаланг экологи, биологи, эрчимжүүлэлтийн чиглэлээр хөгжүүлэх асуудал тулгарч байгаа өнөө үед ээлжлэн тариалалтын ач холбогдол улам нэмэгдэж байна.

Иймд үр тарианы ээлжлэн тариалалтанд шинээр таримал сонгон оруулж таримлын бүтцийг боловсронгуй болгох замаар фермерийн аж ахуйн нөхцөлд зохицсон, нэгж талбайгаас их бүтээгдэхүүн өгч хөрсний үржил шимийг бууруулахгүй хамгаалж чадахуйц агро эдийн засгийн хувьд ашигтай ээлжлэн тариалах системийг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үр тарианы ээлжлэн тариалалт

Гол таримлыг сайн уриншид тариалах зарчим баримтална. Үрийн тариаланд үр тариа уриншийн 2 талбайт сэлгээ хэрэглэнэ.

А. 1. Уринш 2. Буудай

Б. 1. Уринш 2. Үр тариа

Таваарын үр тариа зонхилдог нутгуудад үр тариа уриншийн 3-5 талбайт ЭТС-ийг зөвлөж байна.

А. 1. Цулгуй уринш 2. Буудай 3. Буудай

Б. 1. Цулгуй уринш 2. Буудай 3. Тэжээлийн үр тариа

В. 1. Цулгуй уринш 2. Буудай 3. Эзэмшилт уринш /вандуй+хошуу будаа/ 4. Буудай

Г. 1. Цулгуй уринш 2. Буудай 3. Тэжээлийн үр тариа 4. Эзэмшилт уринш 5. Буудай

Д. 1. Цулгуй уринш 2. Буудай 3. Тэжээлийн үр тариа+хошоон өвс 4. Ногоон бордоот уринш 5. Буудай 6. Тэжээлийн үр тариа

Цаг уурын хувьд чийглэгдүү сэрүүн, хуурайдуу сэрүүвтэр нутгуудад ЭТС-ийн Б хувилбарын дагуу уриншийн дараах 2 дахь жилд хошуу будаа арвай тариалахад бүтээгдэхүүний гарц нэмэгдэж хог ургамлын хөнөөл багасна.

Уриншийн дараах 2 дахь жилд намрын хяруу эрт унадаг талбайд арвай, сэрүүвтэр боловч чийгийн хангамж сайтай талбайд хошуу будаа тарих нь илүү үр дүнтэй. Энэ ээлжинд вандуй зэрэг буурцагт ургамлыг өргөн тариалах хэрэгтэй. Орон нутгийн хөрс цаг уурын нөөцийг бүрэн ашиглах, талбай ашиглалтыг

сайжруулах, хөрсний үржил шимийг бууруулахгүй байх, ус салхины элэгдлээс хамгаалах үүднээс 4-5 талбайт ЭТС-ийг 3 талбайт ЭТС-тэй хослон хэрэглэх нь үр дүнтэй.

Үр тариа, төмсний ЭТС

А. 1. Цулгуй уринш 2. Төмс 3.Буудай

Б. 1. Ногоон бордоот уринш, 2. Төмс, 3. Үр тариа+ хошоон өвс

В. 1. Эзэмшилт уринш /вандуй+ хошуу будаа, 2. Төмс, 3.Үр тариа

Үр тариа, тэжээлийн ургамлын ЭТС

А. 1. Цулгуй уринш 2. Буудай 3.Үр тариа

Б. 1. Цулгуй уринш 2. Үр тариа 3. Ногоон тэжээл /эзэмшилт уринш/ 4. Үр тариа

В. 1. Эзэмшилт уринш /вандуй+ хошуу будаа тэжээлд 2. Үр тариа 3. Үр тариа зэрэг тухайн орон нутагт зохицсон сэлгээг нэвтрүүлэх шаардлага бий болсон. Тэжээлийн ургамлыг сэлгээнд оруулснаар эрчимжсэн мал аж ахуйг тэжээлээр хангахад ач холбогдолтой.

Манай орны нөхцөлд 50%-ийн уринштай, уриншийн талбайд 2-3 удаагийн боловсруулалт хийхэд ургамлын үлдэгдэл болох гуурс сүрэл нь устгагдаж хөрс салхинд тэсвэргүй болдог тул элэгдэл эвдрэлээс хамгаалах, түүний учруулах хор хөнөөлийг багасгахад тариалангийн талбайг зурваслах, сүрлэн хучлага үүсгэх бодит шаардлага урган гарч байна.

Хөрсөнд чийг хуримтлуулах чадвараараа “бага усалгаа” гэж нэрлэгдсэн сүрлэн хучлагын талаар УГТЭШХ-д явуулсан судалгааны дүнгээр 3.0-6.0 тн сүрэл цацсан талбайд уриншлалтын эцэст сүрлийн хэмжээ нэг ам метр талбайд 250-400 ш болж хөрс салхинд тэсвэртэй байх нөхцөл бүрдүүлэхээс гадна 0-100 см-ийн гүнд хөрсний чийг 10-20 мм-ээр ихэсч, гандуу жил ургац 1.5-2.0 ц/га-аар нэмэгдэн, ялзмагийн задрал 25-30%-иар буурч тариалан бүхэлдээ тогтворжих бололцоотой дүн гарч байгааг манай тариаланчид ашиглах цаг болжээ.

Үйлдвэрлэлд хөрс хамгаалах чиглэлээр уринш – буудай - ногоон бордуурын ургамлын сэлгээг мөрдөж чадвал ургацыг 13.7-23.0%-иар, хөрсөн дэх ялзмагийн бууралтыг жилд 0.13% буюу 0.25 тн-оор бууруулах боломжтой ба уринш – буудай – төмс – буудай гэсэн сэлгээ нь ургацыг 15.0-19.0%-иар нэмэгдүүлдэг нь УГТЭШХ-ийн судалгаагаар тогтоогдсон байна.

Хөрсний элэгдэл эвдрэлийн зэргийг харгалзан зах зээлийн нөхцөлд нэвтрүүлж болох сэлгээний дараах хэвшлүүд шалгараад байна. Үүнд:

Салхины элэгдэлд дунд зэрэг орсон талбайд

А/

1.Цулгуй уринш

2.Буудай

3.Вандуй+хошуу будаа

4.Буудай

5.Буудай

Б/

1.Цулгуй уринш

2.Буудай

3.Үр тариа+хошоон өвс

4.Ногоон бордуурт уринш

Салхины элэгдэлд хүчтэй орсон талбайд элэгдлийг зогсоож үржил шимийг сэргээх зорилгоор

1.Ногоон бордуурт уринш

2.Буудай

3.Үр тариа, вандуй + өвсний холимог

Эдгээр судалгаагаар дундаас дээш элэгдэл эвдрэлд орсон талбайд цулгуй уриншийн эзлэх хувийн жинг 5-10% хүртэл багасгаж үржил шимийг сэргээх шаардлагатай байгаа юм.

Усалгаатай тариалангийн ЭТС

Төв бүсэд үр тарианы чиглэлээр

А. Буудай - Өргөн мөрт таримал /төмс, буурцагт ургамал, дарш тосны ургамал/гэсэн 2 талбайт

Б. Буудай - тосны рапс – төмс /Богино эргэлттэй энэ сэлгээ нь эдийн засгийн хувьд хамгийн ашигтай боловч хөрсний үржил шимийг амархан доройтуулж болох учир эрдэс болон шим бордоо заавал хэрэглэнэ/

В. Буудай – Буудай - вандуй+ хошуу будаа - өргөн мөрт таримал/төмс,эрдэнэшиш, судан өвс, шар буурцаг/ гэсэн 4 талбайт сэлгээнүүд

Төмс үйлдвэрлэлийн чиглэлээр:


А. Төмс-буудай- буурцагтан

Б. Төмс-эрдэнэшиш даршинд-ногоон тэжээл

I.2. Хадлангийн газрын төлөвлөлт

I.2.1. Хадлан, тэжээлийн хэрэгцээ, хангамж, шаардагдах хадлангийн газрын хэмжээ

ГНС-н тайлангаар Дархан-Уул аймгийн нийт хадлангийн талбай 9072га бөгөөд 6938га талбай нь Хонгор суманд, 2134,5га талбай нь Орхон суманд байна. Статистик мэдээ болон газрын нэгдмэл сангийн тайлангаар тооцоолон үзэхэд Дархан-Уул аймагт улсын дүнтэй харицуулахад нийт хадлангийн газрын 0,5% нь байдаг боловч нийт өвсний 6%-ийг бэлтгэдэг нь нэлээд өндөр тоон үзүүлэлт юм.



Зураг №6. Газрын нэгдмэл сангийн ангиллын зурагт тусгагдсан хадлангийн талбайн байршил

Дархан-Уул аймаг нь 2014 онд 61,7мян.тн өвс, 244,0тн гар тэжээл бэлтгэсэн байна. 2014 он Дархан уул аймгийн нийт малын тоо 324,2мян.толгойд хүрсэн ба улсын нийт малын тоо толгойн 0,62%-ийг эзлэсэн байна.

2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хүснэгт №11

Сумын нэр		2014он					
		Дүн	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Дархан сум	Сумын дүн	69,297	3,168	13,641	46	31,995	20,447
	1-р баг	1,797	140	525	0	864	268
	2-р баг	11,777	764	2,508	0	5,692	2,813
	3-р баг	15,866	710	3,844	35	7,267	4,010
	4-р баг	-	-	-	-	-	-
	5-р баг	536	27	241	0	76	192
	6-р баг	3,027	54	586	4	1,160	1,223
	7-р баг	4,191	112	519	0	1,977	1,583
	8-р баг	1,714	73	211	0	973	457
	15-р баг	4,288	165	1,182	0	1,727	1,214
	Малчин баг	25,198	1,097	4,007	2	11,981	8,111
Өргөө баг	903	26	18	5	278	576	
Орхон сум	Сумын дүн	41,285	1,647	9,250	37	17,825	12,526
	1-р баг, Баян-Өлзийт	19,147	706	3,622	0	8,535	6,284
	2-р баг, Энхтал	22,138	941	5,628	37	9,290	6,242
Хонгор сум	Сумын дүн	172,794	7,600	18,090	6	97,633	49,465
	1-р баг	23,287	605	3,114	0	11,259	8,309
	2-р баг	128,008	6,022	12,303	0	74,638	35,045
	3-р баг, Салхит баг	21,499	973	2,673	6	11,736	6,111
Шарын гол сум	Сумын дүн	40,865	1,758	5,620	0	20,164	13,323
	1-р баг, Хайрхан	2,525	192	406	0	1,238	689
	2-р баг, Дархан	2,876	79	972	0	1,019	806
	3-р баг, Санжинт	35,464	1,487	4,242	0	17,907	11,828
Аймгийн дүн		324,241	14,173	46,601	89	167,617	95,761

Дархан-Уул аймгийн бэлчээрийн газрын даац маш ихээр хэтэрсэн байгаа тул төлөвлөлтийн үе шатуудад малын тоо толгойг аль болох нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолон хадлангийн хэрэгцээг бодож гаргасан болно.

Дархан-Уул аймгийн жилд шаардлагатай хадлан тэжээлийн хэрэгцээ

Хүснэгт №12

Сумын нэр	Дүн	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Дархан сум	69,297	3,168	13,641	46	31,995	20,447
Орхон сум	41,285	1,647	9,250	37	17,825	12,526
Хонгор сум	172,794	7,600	18,090	6	97,633	49,465
Шарын гол сум	40,865	1,758	5,620	0	20,164	13,323
Дүн	324,241	14,173	46,601	89	167,617	95,761
Шаардагдах өвсний хэмжээ/тн/	40,695		18453.9	117.4	14079.8	8043.9
Шаардлагатай нэмэлт тэжээл /тн/	8,394		8388.1	5.3		

Дархан-Уул аймгийн хувьд бэлтгэдэг хадлангийн өвсний хэмжээ хангалттай байхаар байгаа бөгөөд харин цаашид нэмэлт гар тэжээл болон, үйлдвэрийн тэжээл ихээхэн хэрэгцээтэй байна. Дархан-Уул аймаг нь Эрчимжсэн МАА болон Хагас эрчимжсэн МАА-н чиглэлээр ихээхэн хөгжих бололцоотой бөгөөд орон нутгийн зүгээс ч энэ чиглэлд ихээхэн анхаарал хандуулж байна. Иймд цаашид

үйлдвэрийн тэжээл, мөн эрдэс тэжээл бэлтгэх чиглэлд онцгой анхаарах шаардлагатай байна.

1.2.2. Хадлан, тэжээл үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Тус аймгийн хувьд хадлангийн болон тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр ихээхэн боломж нөхцөл сайтай бөгөөд цаашид ч хадлангийн газрын хэмжээг тэлэх боломжтой юм.


Хадлан тэжээл үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт №13

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
1. га-н ургац өндөр	1. үйлдвэрлэл, АА-н зориулалтаар хадах бэлчээр хомс	1. Зах зээлийн эрэлт	1. Хөрсний үржил шимийн хангамж муудсан
2. Механикжилт	2. Эвдрэл доройтол ихээр явагдаж байна	2. Нэмэлт гар тэжээл болон, үйлдвэрийн тэжээл бэлтгэх боломж нөхцөл сайтай	2. Байгаль цаг уур, зуншлагаас хамааралтай
3. Нягтрал ихтэй төвийн бүсэд байршдаг	3. Ургац тогтвортой бус	3. Хадлангийн газрын хэмжээнөөц	3. Хадлангийн газрын тэлэх нөөц, бусад газар ашиглалтаас хамааран хязгаарлагдана
4. Хадлангийн газрын байршил нь Газар тариалангийн бүсэд байдаг нь малын хөлөөс хамгаалагддаг	4. Ангилан хадалт, ургамлын хадах үе шатанд тохируулга хийдгүйгээс гарц муудаж байгаа		

1.2.3. Хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг ургамалжилт болон 1га-н ургацын хэмжээ гэсэн үндсэн шалгуураар 5 шатлалт баллаар үнэлэв.



Зураг №7. Хадланд тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур


Хадланд тохиромжтой байдлын үнэлгээ

Хүснэгт №14

Ургамалжилтын хувьд		Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь/%/
Нэн тохиромжтой	20682.5 га	6.5
Дунд зэрэг тохиромжтой	34377.3 га	10.7
Тохиромжтой	74206.4 га	23.1
Тохиромжгүй	191352.3 га	59.7
Дүн	320618.5 га	100.0
Дундаж ургацын хувьд		Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь/%/
Нэн тохиромжтой	18274.5 га	5.7
Тохиромжтой	32915.2 га	10.3
Хязгаарлагдмал тохиромжтой	68836.9 га	21.5
Тохиромж муутай	200591.7га	62.6
Дүн	320618.5	100.0

1.2.4. Хадлангийн газрын ашиглалт хамгаалалтын сайжруулах, арга хэмжээ

Дархан-Уул аймгийн одоогийн бүртгэлтэй хадлангийн газрууд нь ургамалжилтын хувьд 50,8% нь тохиромж муутай, 33,2 хувьд хязгаарлагдмал тохиромжтой, 7,8% нь тохиромжтой, 8,3% нь нэн тохиромжтой ангилалд багтаж байна. 1га-н дундаж ургацын хувьд 20,4% нь нэн тохиромжтой, 5,6% нь тохиромжтой, 40,3% нь хязгаарлагдмал тохиромжтой, 33,7% нь тохиромж муутай ангилалд багтаж байна.



Зураг №8. Одоогийн бүртгэлтэй хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Дээрхи тохиромжтой байдлын үнэлгээний зургаас харахад хадлангийн зориулалтаар ашиглахад нэн тохиромжтой болон тохиромжтой газрууд ургацын хувьд хязгаарлагдмал тохиромжтой болон, тохиромж муутай ангилалд багтаж

байна. Энэ нь тус хадлангийн газруудыг олон жилийн хугацаанд буруу ашигласнаас үүдэлтэй.

Цаашид хадлангийн газрыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд нэн тэргүүн ээлжинд эзэмшүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн хадлангын газрыг сайжруулж ургац нэмэгдүүлэх, энэ чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хадланд ашиглахаар хөдөө аж ахуйн эдэлбэр олгохыг бүх талаар дэмжвэл зохино.

Хадлангийн газрын ургацыг нэмэгдүүлэх хамгын үр ашигтай арга нь усалгаа байдагиймд гол, горхины дагуу боломжтой газруудад хайгуул, зураг төсөл хийлгэх, энгийн хялбар хямд төсөр аргаар халиаж услах ажлыг өргөжүүлэх шаардлагатай.

Хадлангийн газрын ургац, төлөв байдлыг сайжруулж, хадлангийн ургацыг нэмэгдүүлэх боломжийг хангаж, тэжээлийн баазыг тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлэхэд тордон сайжруулалтын дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Сэндчилэх: Ихэвчлэн хээржсэн нугын дунд зэрэг талхлагдсан бэлчээрт хавар хөрс гэмэгц бордоо бууц цацсаны дараа фрезрээр хөрсний өнгөн хэсгийг 8-10см буталж царгас хошоон өлөнгийн үр цацаж борнойдож булдана.
2. Үр нэмэрлэн тарих арга: Жил бүр хадсанаас ургамалжилт нь сийрэгжиж байгаа нугын хадланг хавар 6-р сарын сүүлчээр 2-3 удаа шүдэт борной явуулж, үрлэгчээр буюу гараар ерхөг, согооворын үрийг га-д 10-15кг, царгасын үрийг 5-6кг-р бодож тариална.
3. Бордох: Чийгийн хангамж сайтай нугын хөндийн хадланд бордоо цацагчаар азот 60-90кг, фосфор 40-60кг, кали 30-40кг үйлчлэх бодис байхаар бордоно.
4. Чулуу цэвэрлэх: Хадлан бэлчээрийн шаардлагатай талбайн чулууг машинаар эсвэл гараар түүх, том чулууг трактороор зайлуулах
5. Довон тэгшлэх: Нуга, нугархаг хээрийн довонтой хадланг хавар бордоо цацсаны дараа хүнд борнойгоор хөндлөн гүнд 2-3 удаа сэндчилэн, фрезрийг 8-12см-н гүнд явуулж булдана.
6. Сөөг цэвэрлэх: Зөвхөн тэжээлийн нөөц нэмэгдүүлэх боломжтой газар сөөг цэвэрлэнэ. Бут сөөг хэрчигчээр сөөгийг хэрчих буюу авч хүнд борнойгоор дискдэж тэгшилнэ.

I.3. Уламжлалт МАА-н, бэлчээрийн газрын төлөвлөлт

I.3.1. Мал аж ахуйн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамж

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нь манай улсын стратегийн ач холбогдол бүхий салбар бөгөөд хүн амын хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг юм. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатууд дахь хүн амын хэрэгцээг дараахь байдлаар тодорхойлж байна.

Аймгийн хүн ам 2020 онд 99.0, 2025 онд 102.1, 2030 онд 104.4 мянгад хүрэхээр байна. Иймд өсөн нэмэгдэх хүн амын хэрэгцээг тооцоолж түүнд тохирсон менежментийг хийх нь чухал юм. Мал аж ахуйн гаралтай стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болох мах, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг төлөвлөлтийн жилүүдэд хэдий хэмжээтэй байхыг 2008 оны эрүүл мэндийн сайдын 257-р тушаалын 5-р хавсралтад заагдсан нэг хүний хоногийн дундаж хэрэглээний нормыг /хүснэгт№15-18/ашигласан.

Стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн болох махны хэрэгцээг бодохын өмнө Монгол улсын болоод аймгийн хэмжээнд үйлдвэрлэх боломжтой махны хэмжээг тооцоолов. Уг тооцоонд жил бүр нийт сүргийн 15%-ийг эргэлтээр ашиглахад хэдий хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтойг тогтоосон бөгөөд тэмээнээс гарч болох үйлдвэрлэлийн хэмжээг уг тооцоонд оруулаагүй тооцоолов.

Махны үйлдвэрлэлийн боломжит хэмжээ

Хүснэгт №15

#		Дүн	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Одоогийн малын тоо	Улсын хэмжээнд	51,982,583	2,995,754	3,413,851	349,299	23,214,783	22,008,896
	Аймгийн хэмжээнд	324,241	14,173	46,601	89	167,617	95,761
Сүргийн 15%	Улсын хэмжээнд	7,797,387	449,363	512,078	52,395	3,482,217	3,301,334
	Аймгийн хэмжээнд	48,636	2,126	6,990	13	25,143	14,364
Боломжит үйлдвэрлэл /тн/	Улсын хэмжээнд	3702364.3	67404.5	76811.6		3558148.1	
	Аймгийн хэмжээнд	26840.3	318.9	1048.5		25472.9	

Үүний дараагаар нийт хүн амд шаардагдах махны хэрэгцээнд төлөвлөлтийн жилүүдээр тооцоолон гаргаж дор үзүүлэв мөн боломжит үйлдвэрлэлийн хэмжээтэй харьцуулан зах зээлийн багтаамжыг тооцоолов.

Хүн амын махны хэрэгцээ, зах зээлийн багтаамж

Хүснэгт №16

Төлөвлөлтийн жилүүд	хүн ам	Шаардагдах хэрэгцээ /тн/	Боломжит үйлдвэрлэл.тн /Нийт сүргийн 15%/	Илүүдэл/дутагдал.тн	
2020	Улсын хэмжээнд	3,151,086	283597.7	3702364.3	3418766.5
	Аймгийн хэмжээнд	99,058	8915.2	26840.3	17925.1
2025	Улсын хэмжээнд	3,377,503	303975.3	3702364.3	3398389.0
	Аймгийн хэмжээнд	102,125	9191.3	26840.3	17649.1
2030	Улсын хэмжээнд	3,576,877	321918.9	3702364.3	3380445.3
	Аймгийн хэмжээнд	104,426	9398.3	26840.3	17442.0

Дээрхи хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд төдийгүй, улсын хэмжээнд махны зах зээлд илүүдэл гарахаар байгаа нь ажиглагдаж байна.

Гэвч зах зээл дээр улирлаас хамааралтай нийлүүлэлтийн илүүдэл болон дутагдал байнга гардаг судалгаа байдаг энэ нь Монгол улсын МАА-н салбарын махны үйлдвэрлэлийн дийлэнхи хэсэг нь нүүдлийн МАА-с бий болдог бөгөөд нүүдлийн МАА нь тогтвортой үйлдвэрлэл явуулах боломжгүй байдаг. Үүнийг бидний хийсэн SWOT шинжилгээнээс харах боломжтой.

Мөн бидний уламжлалт хэрэглээ бөгөөд дэлхийн хүн амын зайлшгүй чухал хэрэгцээний нэг болох сүү сүүн бүтээгдэхүүний шаардагдах хэмжээ болон зах зээлийн багтаамжыг тооцоолж үзье.

Үүний тулд мөн адил боломжит үйлдвэрлэлийн хэмжээг тооцоолон, төлөвлөлтийн жилүүд дэх хэрэгцээний хэмжээтэй харицуулав.

Сүү сүүн бүтээгдэхүүний боломжит үйлдвэрлэл

Хүснэгт №17

#	Малын төрөл	2014 оны статистик /хээлтэгч/	Сүрэгт эзлэж буй хувь	Жилийн дундаж гарц/л/	Саах мал/хээл тэгчид эзлэх хувь/	Саалийн хэмжээ /тн/	Саах мал/хээлтэгчид эзлэх хувь/	Саалийн хэмжээ /тн/
Улсын дүн	Бүгд	22,248,630	42.8			497075.8		846275.0
	Ингэ	120,180	34.4	120	30	4326.5	100	14421.6
	Гүү	895,490	29.9					
	Үнээ	1,333,400	39.1	400	70	373352.0	100	533360.0
	Эм хонь	10,478,000	45.1	30	20	62868.0	50	157170.0
	Эм ямаа	9,421,560	42.8	30	20	56529.4	50	141323.4
Дархан-Уул	Бүгд	152,770	47.1			6521.4		10139.4
	Ингэ	30	33.7	120	30	1.1	100	3.6
	Гүү	4,470	31.5					
	Үнээ	20,550	44.1	400	70	5754.0	100	8220.0
	Эм хонь	81,780	48.8	30	20	490.7	50	1226.7
	Эм ямаа	45,940	48.0	30	20	275.6	50	689.1

Дээрхи тооцоололд Монгол улсын ХАА-н салбарын мастер төлөвлөгөөнд дурдсан тоо баримтуудыг ашигласан ба гүүний саам нь монголчуудын уламжлалт гол хэрэглээний нэг боловч нэг хүнд шаардлагатай үндсэн стандарт хэрэглээг тооцоход оруулан тооцоогүй. Одоогийн үйлдвэрлэлийн дундаж тооцооллыг гаргахад саах малын хэмжээг улсын дундажаар бодсон ба мөн түүнийг нэмэгдүүлэхэд ямар хэмжээний сааль авах боломжтойг тооцоолов.

Дээрхи тооцооллыг хүн амын хэрэгцээнд шаардлагатай сүүний хэмжээтэй харьцуулахад доорхи байдалтай байна.

Хүн амын сүүний хэрэгцээ, хангамж

Хүснэгт №18

Төлөвлөлтийн жилүүд	Бүтээгдэхүүний нэр	хүн ам	Шаардаг дах хэрэгцээ /тн/	Цэвэр сүүнд шижүүлсэн хэрэгцээ/тн/	Одоогийн үйлдвэрлэл /тн/	Илүүдэл/ дутагдал. тн	
2020	Улсын хэмжээнд	Сүү	3,151,086	230029.3	637181.1	497075.8	-140105.3
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	3,151,086	339293.2			
	Аймгийн хэмжээнд	Сүү	99,058	7231.2	20030.5	6521.4	-13509.1
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	99,058	10666.1			
2025	Улсын хэмжээнд	Сүү	3,377,503	246557.7	682964.9	497075.8	-185889.0
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	3,377,503	363672.6			
	Аймгийн хэмжээнд	Сүү	102,125	7455.1	20650.7	6521.4	-14129.3
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	102,125	10996.3			
2030	Улсын хэмжээнд	Сүү	3,576,877	261112.0	723280.3	497075.8	-226204.5
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	3,576,877	385140.2			
	Аймгийн хэмжээнд	Сүү	104,426	7623.1	21116.0	6521.4	-14594.6
		Тараг аарц, сүүн бүтээгдэхүүн	104,426	11244.1			

Тус тооцооллоос харахад хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний стандарт хэрэгцээг улсын хэмжээнд болон аймгийн хэмжээнд бүрэн хангаж чадахгүй байгаа ба мөн улирлын чанартай бүтээгдэхүүн нийлүүлэлт нь эрэлтээ бүрэн хангаж чадахгүй нөхцөл үүсгэдэг. Иймд цаашид МАА-н салбарт үйлдвэржсэн тасралтгүй нийлүүлэлттэй ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН хэрэгцээ асар их байгааг харуулж байна.

1.3.2. Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт №19

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл(O)	Таагүй нөхцөл (Т)
1. Хадлан, бэлчээрийн ургац өндөр	1. Газар нутаг багатай, бэлчээрийн даац багтаамж хэтэрсэн	1. Бүтээгдэхүүн зах зээлд эрэлт ихтэй	1. Иргэдийн өмч тул үржил селекци, сүргийн эргэлтийг зохион байгуулах боломжгүй
2. Хөрөнгө оруулалт багатай	2. Менежмент сул	2. Эрчимжүүлэх, удмын санг сайжруулаж бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх боломжтой	2. Байгаль цаг уураас шалгаалсан эрсдэл өндөртэй
3.Хадлан тэжээлийн хангамж сайтай	3. Бүтээгдэхүүн гарц нь улирлын хамааралтай, ашиг шим бага	3. Байгаль экологийн нөхцөл сайтай	3. Усан хангамж, уст цэг дагадаг
4. Малын тэсвэрт чанар өндөр	4. Сууришлын бүс болон, газар тариалангийн бүсэд шахагддаг		

1.3.3. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны материалд үндэслэн “бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулсан бөгөөд 1-р үе шатанд ургамлан нөмрөгийн тэжээллэг чанар болон

ашигт чанарыг харгалзан тохиромжтой байдлыг үнэлэв. Уг үнэлгээгээр өвөл-хаврын улирлын ашиглалт, зун-намрын улирлын ашиглалт 1-ээс 4 шаталбарт баллаар үнэлэн боловсруулав. Үүнд:

- Нэн тохиромжтой
- Тохиромжтой
- Дунд зэрэг тохиромжтой
- Тохиромж муутай гэсэн үнэлэмжийг ашигласан болно.


Уг үнэлгээ нь Дархан-Уул аймгийн нийт нутаг дэвсгэр болох 320618.48га талбайг хамарсан 901нэгж талбарт /бэлчээрийн хянан баталгааны тайлан/ хуваагдах бөгөөд үүнээс бэлчээрийн эдэлбэрээр ашиглах боломжгүй 759 нэгж талбар байсан ба нийт талбайн хэмжээ 107562.64га байгаа бөгөөд нийт газар нутгийн 33.5%-г эзлэж байна /үүнд: ой бүхий газар, нуур цөөрөм тойром, тариалангийн газар гэх мэт бэлчээрийн эдэлбэр бус газрууд хамаарна/.

Тус үнэлгээнээс харахад нийт нутаг дэвсгэрийн 43.9% нь зун намрын улиралд бэлчээрийн зориулалтаар ашиглахад нэн тохиромжтой, 12.2% нь өвөл хаврын улиралд бэлчээрийн зориулалтаар ашиглахад нэн тохиромжтой нутаг байна.

Бэлчээрийн эдэлбэр газрын зун намрын улиралд тохиромжтой байдал

Хүснэгт №20

Тохиромжтой байдалын үнэлгээ	Хамрагдах контурын тоо	Эзлэх талбай /га/	Эзлэх хувь
Бэлчээрийн эдэлбэр бус газар	759	107562.64	33.5
Нэн тохиромжтой	78	140851.7	43.9
Тохиромжтой	63	71334.5	22.2
Дунд зэрэг тохиромжтой	1	869.6	0.3
Тохиромж муутай	0		
Дүн	901	320618.5	100




Зураг №9. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Бэлчээрийн эдэлбэр газрын өвөл хаврын улиралд тохиромжтой байдал

Хүснэгт №21

Тохиромжтой байдлын үнэлгээ	Хамрагдах контурын тоо	Эзлэх талбай /га/	Эзлэх хувь
Бэлчээрийн эдэлбэр бус газрууд	759	107562.64	33.5
Нэн тохиромжтой	36	39091.4	12.2
Тохиромжтой	90	153806.9	48.0
Дунд зэрэг тохиромжтой	16	20157.5	6.3
Тохиромж муутай	0	0	0
Дүн	901	320618.5	100



Зураг №10. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

1.3.4. Бэлчээрийн газрын ашиглалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ

Бэлчээрийн газрын төлөвлөлтийн зорилго нь жилээс жилд хомсдох байдалтай байгаа бэлчээрийн газрыг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан нөхөн сэргээх, сайжруулах замаар байгалийн нөөцийг хамгаалах, тогтвортой хэмжээнд барихад чиглэсэн болно. Энэ зорилгыг хэрэгжүүлэх үндэслэл нь энэ онд гарсан Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Засгийн газарт чиглэл өгөх тухай" зарлиг, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргасан Үндэсний болон үе үеийн Засгийн газруудын хөтөлбөрүүд, Шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Хүнс, Хөдөө аж ахуйн салбарыг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Малын үржлийн ажлын стратеги Төлөвлөгөө (2009-2021 он), Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол зэргийг харгалзан үзсэн болно.

Дархан-Уул аймгийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд 2020, 2025, 2030 оны төвшинд байх хүн амын мах, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, зах зээлд нийлүүлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг харгалзан, сүргийн бүтэцийг зохистой болгох, малын тоог тогтвортой барих замаар бэлчээрийн даацад малын тоо, толгойг тохируулах бодлого баримталсан бөгөөд махны хангамжын хувьд боломж хангалттай байгаа ба сүү сүүн бүтээгдэхүүний хувьд дутмаг байхаар байна.

МАА-н салбарын хувьд зах зээлийн нийгэмд шилжсэнээр буюу малыг малчдад хувьчилсанаар Монгол улсын малын тоо толгой өссөн боловч, сүргийг чанаржуулах, сүргийн эргэлтийг зохион байгуулах ажлууд хийгдэлгүй өнөөг хүрсэн нь бэлчээрийн даац багтаамжид тулгуурласан төлөвлөлт хийхэд хүндрэлтэй болсон.

Мөн бэлчээр нутгийн зохион байгуулалт, менежмент байхгүйгээс бэлчээр эзэнгүйдэж малчид дураар нутаглаж, бэлчээрийг сэлгэж өнжөөх, амраах, даац багтаамжид тохируулга хийн отор нүүдэл хийх зэрэг бэлчээрийг хамгаалах ажлууд орхигдсон байна. Хуулийн дагуу бэлчээр нутаг нь төрийн өмч бөгөөд төрийг төлөөлөн орон нутгийн захиргаа бэлчээрт хяналт тавих, даац багтаамжид тохируулга хийх, сайжруулах, хамгаалах арга хэмжээг авах эрхтэй байдаг.

Тус аймгийн бэлчээрийн газрын хувьд жилийн даац багтаамж 191365 хонь толгой бөгөөд 2014 оны жилийн эцсийн байдлаар 642818 хонь толгой мал байгаа бөгөөд бэлчээрийн даац 235,9% хувь хэтэрсэн гэсэн тооцоололтой байна. Гэхдээ Дархан-Уул аймгийн малчдын дийлэх хэсэг нь зэргэлдээх аймгийн сумдуудад нутагладаг нь уг малын нийт тоонд нөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй. Нийт малын 50% зэргэлдээх аймгийн сумдад байдаг гэж үзвэл бэлчээрийн даац мөн 67,9%-р хэтэрсэн байхаар байна.

Бэлчээрийн газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны материалаас үзэхэд нийт бэлчээрийн 20% дундаас дээш их талхлагдалд өртсөн

байдалтай байна. Ялангуяа бэлчээр нутаг багатай Орхон, Шарын гол сум, мөн Дархан сумын ойролцоох хэсгүүд болон Хараа голын сав дагуух бэлчээрүүд ихээхэн талхлагдсан байна.

Талхлагдаж доройтсон болон талхлагдаж эхэлж байгаа газруудад бэлчээрийн төрх байдал, чанарын өөрчлөлтөнд орсон газрыг нөхөн сэргээх янз бүрийн арга хэмжээ авах шаардлагатай байна. Бэлчээрийн талхлагдал доройтлыг бууруулах, доройтлоос сэргийлэх олон арга байдаг бөгөөд эдгээрээс хөрөнгө хүч бага зарцуулах аргыг сонгох нь зүйтэйгээс гадна уг газар хэний эзэмшилд байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх нь зүйтэй.

Мал бэлчээхгүйгээр бэлчээрийг сэлгэж хамгаалах тохиолдолд тухайн бэлчээртээ тодорхой хугацаанд ямар ч мал оруулахгүй байлгана. Ингэхийн тулд тухайн бэлчээрт мал оруулахгүй байлгахыг хүн бүрийн оролцоотойгоор хянах хэрэгтэй. Малчдын оролцоотойгоор бүлэг дотроо сэлгэн ашиглаж байгаа бэлчээрийн хил хязгаарыг тогтоож, малчид, иргэдэд сайтар ойлгуулж, мал оруулахгүй байх зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Сэлгэж, өнжөөх бэлчээрийн хүрээг тодорхойлох

Мал бэлчээлгүй өнжөөх /сэлгэж ашиглах/ талбайн хил хязгаарийг бэлчээрийн хяналт үнэлгээ, ургамалжлын судалгаан дээр үндэслэн жил бүр шинэчлэн тодорхойлох шаардлагатай. Ургамлын бүрэлдэхүүн, гарц тодорхой хэмжээгээр тогтвортой байгаа бэлчээрийг улирлын байдалд тохируулан сэлгэж ашигласнаар ургамлын нөхөн сэргэлтэд сайнаар нөлөөлөх боломж бүрдэнэ. Бэлчээрийн талхлагдлаас үүдэн ургамал доройтож байгаа бэлчээрийн хувьд удаан хугацаагаар тухайн бэлчээрт мал бэлчээхгүйгээр ургамлын нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

1. Мал бэлчээхгүй байх хугацааг тогтоох-Өвс, ургамлын нөхөн сэргэлт тодорхой хэмжээнд байгаа бэлчээрийг улиралд эсвэл тогтмол хугацаанд өнжөөх
2. Урт хугацаагаар өнжөөх - Бэлчээрийн талхлагдлаас үүдэн ургамал доройтож байгаа бэлчээрийг 1 ба хэд хэдэн жилээр өнжөөх аргуудыг ашиглана

Тогтмол хугацаанд өнжөөх


Малыг бэлчээрийн зонхилох ургамлын өсөлт хөгжилт, сэргэн ургах онцлогт нь тохируулан бэлчээх бөгөөд ургамал цухуйж ургаснаас хойш 2 долоо хоногийн хооронд мал бэлчээхгүй байх /малд идүүлэхгүй байх/ Хавар бороо орж, өвсний гарц сайжрах ба дөнгөж ургаж байгаа үед нь малд идүүлчихвэл ургалт зогсож, бэлчээрийн ургамал дахин сэргэхэд бэрхшээлтэй болно.

Ургамлын үр боловсролтын үе шатанд бэлчээрийг ашиглахгүй байх Намар өвсний үрээ цацах үед бэлчээрийг ашиглалгүйгээр өвсний үр газарт унаж ургахыг хүлээнэ. Иймд бэлчээрийн ургамлын үр боловсорч гүйцтэл бэлчээрт ашиглахаас татгалзах Бэлчээрийн ургамлын ургалт, боловсролтын байдлыг тодорхойлж, бэлчээрийг сэлгэж, өнжөөж ашиглах (эсвэл бэлчээрлэх малын тоо толгойг хязгаарлах) хугацааг тодорхойлох үндэслэл болно.

Урт хугацаагаар бэлчээхгүй өнжөөх (1жил, түүнээс дээш)

Хэт доройтсон бэлчээрийн хувьд нэг жил, түүнээс дээш хугацаагаар бэлчээхийг хориглон, ургамлын нөхөн сэргэх хугацааг тавьж өгөх шаардлагатай.

Мал бэлчээгээгүй өнжөөж мөн сэлгэн ашигласан бэлчээрт доорхи өөрчлөлтүүд гарна. Мал бэлчээгээгүй талбайн ургац, зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж, эерэг үзэгдлүүд ажиглагдана.



Үүнийг хэдэн жилээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд ургамлын гарц сайжирч, удаан хугацаанд тогтвортой ашиглах боломж бүрдэх юм.

Бэлчээрийг хамгаалах, зөв зохистой ашиглах, дунд зэрэг талхлагдалд орсон газруудыг байгалийн аясаар нь нөхөн сэргээхэд 3 сэлгээт ашиглалтын бүдүүвч ихээхэн ач холбогдолтой юм.

Бэлчээрийг дулааны улиралд ашиглах гурван сэлгээт бүдүүвч

Хүснэгт №22

Ашиглах жилүүд	Бэлчээрийн хэсэг, түүнийг ашиглах дараалал		
	I хэсэг	II хэсэг	III хэсэг
Эхний жил	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	Намар /X-XI сард нэг ээлжээр/
Хоёр дахь жил	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	/X-XI сард нэг ээлжээр/	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/
Гурав дахь жил	X-XI сард нэг ээлжээр	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/

Талхлагдсан бэлчээрийг сэргээн сайжруулах сэлгээний бүдүүвч


Хүснэгт №23

Ашиглах дараалал /жилээр/	Бэлчээрийн хэсэг, түүний улирлаар ашиглах дараалал				
	I хэсэг	II хэсэг	III хэсэг	IV хэсэг	V хэсэг
Эхний жил	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр
Хоёр дахь жил	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр
Гурав дахь жил	YIII-X сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө
Дөрөв дэх жил	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр
Тав дахь жил	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр

Талхлагдсан бэлчээрт авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт №24

Ургамалын индекс	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Эзлэх талбай	Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ
22a	Их талхлагдсан хялгана - алаг өвст	669.89	2-3жил өнжөөх
24a+26a	Их талхлагдсан Зүр өвст, Зүр өвс - алаг өвст+Зүр өвс - хялганат	6072.1	2-3жил өнжөөх
106a+134a	Их талхлагдсан Хялгана-хазаарт+Агь- үетэнт	2855.67	2-3жил өнжөөх
106b+134a	Дунд талхлагдсан Хялгана-хазаарт+ Их талхлагдсан Агь- үетэнт	2788.86	2-3жил өнжөөх
108a	Их талхлагдсан Хялгана-биелэгт	1308.15	2-3жил өнжөөх
114a	Их талхлагдсан Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	7737.57	2-3жил өнжөөх
127a	Их талхлагдсан Хялгана- харганат	1187.83	2-3жил өнжөөх
130b+207b	Дунд талхлагдсан Хазаар өвс- хиагт+Алаг өвс- үетэнт	1946.01	1-2жил өнжөөх
195a	Их талхлагдсан Улалж-үетэнт	1897.9	4-5жил өнжөөх
197a	Их талхлагдсан Улалж-алаг өвст	2020.76	4-5жил өнжөөх
208a	Их талхлагдсан Улалж-үетэн-алаг өвст	6631.57	4-5жил өнжөөх
	Дүн	35116.31	



1.3.5. Бэлчээр нутгийг хамгаалах, сайжруулах бусад арга хэмжээ

Доройтож талхлагдсан бэлчээрт авч хэрэгжүүлэх дээрх арга хэмжээнүүдээс гадна бэлчээрийн эдэлбэр газрын үржил шимийг бууруулахгүй байхад чиглэгдсэн дараах нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Жил бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах:Бэлчээрийн менежмент гэдэг нь байгалийн бэлчээрийг зохистой ашиглах, сэргээн сайжруулах, хамгаалж, хадгалах, төрх байдлын хяналт-шинжилгээ хийх зэрэг олон харилцааг багтаасан бэлчээрийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааны цогц юм.

Бэлчээрийг эзэмшүүлэх –энэ асуудлыг малчдын бүлэг, хот айл, нэг нутгийнхан болон боломжтой нутгуудад /Хонгор суманд/ нэг хот айлд эзэмшүүлэх нь арай зохимжтой хувилбар юм.

Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах:Бэлчээрийн даацыг хэвийн хэмжээнээс хэтрүүлсэн нөхцөлд бэлчээр ашиглах арга ажиллагааг яаж ч сайжруулаад олигтой үр дүнд хүрэхгүй, бэлчээр муудан, муудсаар доройтолд л орно. Сумдын бэлчээрийн өвс, ургамлын бүтэц харилцан адилгүй ургац нь их, бага байдаг. Бас тухайн жилийн өнгө хур тундас, дулаан, хүйтнээс хамаарч ургац тогтворгүй байна. Гэвч ямар ч үед тодорхой тооны малыг тэжээх чадавхитай байх тул энэ чадавхи болох бэлчээрийн даацыг жил бүр тогтоож, бэлчээрийн даацдаа тохируулан мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх шаардлага байна.

Шинээр зэлүүд бэлчээр эзэмших: Ашиглалт багатай болон ашиглалтгүй бэлчээр нутгийг ашиглах нь ачаалал өндөр талхлагдаж доройтсон бэлчээр нутагт даац тохируулах, өнжөөх сэлгэх зэрэг арга хэмжээ авах боломжыг олгоно.

Цаг хүндэрсэн үед ашиглах нөөц нутаг, отрын бэлчээр бий болгох:Малчдын бүлэг, баг, сумын хэмжээнд ган, зудын үед ашиглах аюулаас хамгаалах нөөц нутагтай байх нь бэлчээрийн зөв менежментийг хэрэгжүүлэх нэг чухал үзүүлэлт болдог. Хэрэв өөрийн сумын нутагт нөөц нутаг гаргах боломжгүй бол аймгийн ИТХ-д санал оруулж сум дундын отрын нутгаас газар тогтоолгож авсан байх шаардлагатай.Нөөц нутгийг ашиглах ажлыг журамлаж, бууц, хонд бэлтгэх, уст цэгийг нэмэгдүүлэх, отор нүүдлээр дамжин өнгөрөх цэгүүдийг товлож тогтоосон байна. Ган зудын үед малчдын бүлгийг хэдий хэмжээний малтай, хаашаа шилжүүлж нүүлгэх тухай төлөвлөгөөнд тодорхой тусгана.

Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх. Бэлчээрийг мэрэгчдийн хөнөөлөөс хамгаалах ажлыг жил бүрийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байх шаардлагатай бөгөөд бэлчээрийг хөнөөлөөс хамгаалах асуудлын нэг нь бэлчээр дэх мэрэгчдын тоог хэт олшруулахгүй байх, мэрэгчдийн тоо олширч буй шалтгааныг цаг алдалгүй зөв тогтоож тэмцэх аргыг зөв сонгон хэрэглэх явдал юм. Бэлчээрийн хортон мэрэгчдийн тархах, өсөн үржих таатай нөхцөл нь талхлагдсан, сийрэг, тачир ургамалтай бэлчээр байдаг. Иймд бэлчээрийг олон жилээр давтан ашиглах нь үлийн цагаан оготнын үржих таатай нөхцлийг бүрдүүлдэг. Бэлчээрийн мэрэгчидтэй тэмцэх хамгийн шалгарсан арга бол бэлчээрийг талхлахгүй байлгах явдал юм.

I.4. Эрчимжсэн АА-н бүсийн төлөвлөлт

I.4.1. Эрчимжсэн АА-г хөгжүүлэх бүсийн үнэлгээ

Эрчимжсэн мал аж ахуйг сонгомол утгаар нь сүүний, махны үхрийн аж ахуй, гахай, шувууны аж ахуйг үйлдвэрийн аргаар байнгын байр тэжээлтэй үйлдвэржсэн аж ахуй эрхлэнэ гэж үзвэл ихээхэн хэмжээний тэжээл шаардлагатай Дархан-Уул аймгийн хувьд Монгол улсын газар тариалангийн төв бүсэд оршдог нь ихээхэн давуу тал болж байгаа юм.

Эрчимжсэн МАА салбарын SWOT шинжилгээ


Хүснэгт №25

Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл(O)	Таагүй нөхцөл (T)
1. Хадлан, бэлчээрийн ургац өндөр	1. Газар нутаг багатай	1. Зах зээлийн эрэлт	1. Бүх иргэдийг хамруулах боломжгүй
2. Зам харилцаа, дэд бүтэц сайтай	2. Уламжлалт бэлчээрийн МАА-г шахах	2. Иргэдийн хүсэл сонирхол	2. Малчин өрхүүдийн зах зээлд нөлөөлөх
3. Нягтрал ихтэй төвийн бүсэд байршдаг	3. Тэжээлийн үйлдвэрлэл хангамж муу тай	3.Тэжээлийн үйлдвэр байгуулах боломжтой	
4. Хадлан тэжээлийн хангамж сайтай	4. Хөрөнгө оруулалт шаардана	4. МАА-н эрдэл буурна	

Эрчимжсэн МАА-н саалийн нэг үнээнд жилд 2 тн өвс, 1.8 тн багсармал, 8 тн өвсөн дарш, 1 тн үндэс үртэн, 1.2 кг эрдэс давс шаардлагатай гэж тооцвол 15 үнээтэй жижиг фермерт өвс 30 т, багсармал тэжээл 27 тн, өвсөн дарш 120 тн, тэжээлийн үхэр манжин 15 тн -ыг бэлтгэх юмуу алсаас худалдан авах шаардлага гарна. Энэ хэмжээний тэжээлийг хаана бэлтгэхээс хамаарч тээврийн зардал нэмэгдэнэ. Харин цус сайжруулсан нутгийн үхрийг хагас суурин маллагаатай, өвлийн 240 хоногт 4-6 кг багсармал, 8 кг өвсөөр нэмэгдэл маягаар тэжээнэ гэвэл нутгийн 15 үнээнд 18 тн багсармал тэжээл, 28 тн өвс хэрэгтэй болно.

Орон нутгаас 11 байршилд эрчимжсэн АА хөгжүүлэх бүс байгуулах санал өгсөн ба уг бүсүүдэд нөөц нөхцлийн үнэлгээ хийхдээ 50-н үнээний жишиг фермийн хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулсан ба усалгаагүй газарт нэг үнээнд 2.5 га бэлчээр, хадлан, 2 га тариалангийн талбай /таримал тэжээл болон таримал бэлчээрт зориулан/ байхаар тооцоолов.

Мөн газар тариалангийн бүс орчмын бэлчээр нутгийг хагас эрчимжсэн МАА-н бүс нутаг болгохоор санал өгсөн байна.



Зураг №12. Эрчимжсэн АА хөгжүүлэх бүс нутгийн нөөц, нөхцлийн үнэлгээ

Эрчимжсэн АА хөгжүүлэх бүс нутгийн нөөц, нөхцлийн үнэлгээний тайлбар

Хүснэгт №26

№	Сум	Талбайн хэмжээ	Тэжээл тариалах боломжтой эсэх	Бэлчээр	Хадлан	Усан хангамж	Зам харилцаа	Боломжит АА-н тоо хүчин чадал
1	Орхон	768.37	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Тохиромжтой	Дунд зэрэг	Хатуу хучилттай замд ойр	150 үнээний хүчин чадал бүхий ферм
2	Орхон	420.82	Тохиромжтой	Тохиромжтой	40% нь нэн тохиромжтой	Дунд зэрэг	Хатуу хучилттай замд ойр	100 үнээний хүчин чадал бүхий ферм
3	Орхон	116.13	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Тохиромжтой	Сайн	Хатуу хучилттай замд ойр	50 үнээний хүчин чадал бүхий ферм
4	Орхон	189.5	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Бүсэд хамраах газарт тохиромжгүй	Сайн	Хатуу хучилттай замд ойр	50 үнээний хүчин чадал бүхий ферм
5	Хонгор	335.87	40% нь тохиромжтой, 60% хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжтой	Тохиромжтой	Сайн	Хатуу хучилттай замд ойр	100 үнээний хүчин чадал бүхий ферм
6	Хонгор	119.35	60% нь тохиромжтой, 40% хязгаарлагдмал тохиромжтой	45% нь нэн тохиромжтой, 55% нь тохиромжтой	50% нь тохиромжтой	Сайн	Шарын гол сумруу зам тавьгдсан нөхцөлд сайн	50 үнээний хүчин чадал бүхий ферм
7	Хонгор	543.19	90% нь тохиромжтой, 10% хязгаарлагдмал тохиромжтой	Нэн тохиромжтой	Бүсэд хамраах газарт тохиромжгүй	Дунд зэрэг	Хатуу хучилттай замд ойр	100 үнээний хүчин чадал бүхий ферм
8	Хонгор	487.15	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Бүсэд хамраах газарт тохиромжгүй	Дунд зэрэг	Хатуу хучилттай замд ойр	100 үнээний хүчин чадал бүхий ферм
9	Хонгор	679.2	70% нь тохиромжтой, 30% хязгаарлагдмал тохиромжтой	Нэн тохиромжтой	30% нь тохиромжтой	Муу	Хатуу хучилттай замд 10км	50 үнээний хүчин чадал бүхий ферм
10	Хонгор/ Шарын гол сумаас санал өгсөн/	193.35	60% нь тохиромжтой, 40% хязгаарлагдмал тохиромжтой	50% нь нэн тохиромжтой, 50% нь тохиромжтой	50% нь тохиромжтой	Муу	Хатуу хучилттай замаас хол боловч, Шарын гол суманд ойр	50 үнээний хүчин чадал бүхий ферм
11	Хонгор/ Шарын гол сумаас санал өгсөн/	69.95	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Бүсэд хамраах газарт тохиромжгүй	Муу	Хатуу хучилттай замаас хол боловч, Шарын гол суманд ойр	25 үнээний хүчин чадал бүхий ферм

1.4.2. Эрчимжсэн АА хөгжүүлэх бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дархан-Уул аймгийн хувьд Эрчимжсэн, болон хагас эрчимжсэн АА-н 2 бүсийг төлөвлөөд байгаа.

1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал эрчимжсэн аж ахуйн бүс /өмнө дурдсан 11 байршилд хүчин чадал, газрын багтаамжаас хамааруулан олгоно/Эдлэн газрын хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, нутаг дэвсгэрийн хувиарлалтын дагуу газар эзэмших эрхийн гэрээнд заасан болзол, нөхцлөөр нарийн төрөлжсөн , эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермер, аж ахуйн нэгжийн газрыг энэ бүсэд хамруулан авч үзэв. Энэ бүсийг эрчимжсэн мал аж ахуйн бүс гэж ойлгож болно.Энэ бүсэд эзэмшлийн газрын байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах асуудлыг газар эзэмшигч бүрэн хариуцах бөгөөд үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулна. Энэ бүсэд үйлдвэрлэл эрхэлж буй газар эзэмшигчийн үндсэн үүрэг нь нийслэлд зайлшгүй хэрэгцээтэй мал аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэхэд чиглэгдэнэ. Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэл явуулах учир ашиг шимийн төрөлжилтийн бус бусад төрлийн мал, амьтан холилдон нутаглах, бусдын мал дамжин өнгөрөхийг тусгай эрх зүйн актын дагуу хатуу хориглох арга хэмжээ авна.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

- Санал болгож буй газрыг үр ашигтай ашиглах хөгжлийн төслүүдийг урьдчилан боловсруулна. Нэг эдлэнгийн хэмжээ урьдчилан нормчлогдсон байна. Нутгийг түүнд тохируулан хуваарилсан байх бөгөөд төсөлд заасан болзол нөхцлийн дагуу нарийн төрөлжсөн үйлдвэрлэлийг эрхлэх аж ахуйн нэгжид тэдгээр хуваарьт эдлэнг бат тогтвортойгоор эзэмшүүлнэ.
- Эзэмшлийн газрын төлөв байдлыг хадгалах, хамгаалах асуудлыг газар эзэмшигч хариуцаж газар ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор оюуны өндөр багтаамжтай технологи нэвтрүүлнэ.
- Эдлэн газрыг хашаалж дотор нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг багтаан явуулахуйц газар ашиглалтын арга технологи хэрэглэн зөвхөн нийслэлд зайлшгүй хэрэгтэй бүтээгдэхүүн ажил үйлчилгээ эрхлэнэ.
- Ашиг шимийн төрөлжилтийн бус мал аж ахуй эрхлэхийг хаана.
- Өөр нутгаас мал бүхий иргэд шилжин суурьших, дамжин нутаглахыг хориглоно.

2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газартай хосолмол аж ахуйн суурьшлын бүс /Газар тариалангийн бүсийн ойролцоох бэлчээр нутаг хамрагдах ба малчдын бүлэг, нөхөрлөл зэргийг дэмжин хөгжүүлэх боломжтой, уламжлалт бэлчээрийн МАА-г хязгаарлах бүс юм /Энэ бүсэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглохгүй боловч сүү, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлийг хэтийн зорилго болгоно. Иймээс эрчимсэн мал аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжид газар хуваарьлан эзэмшүүлнэ. Малын

тэжээл бэлтгэх, төмс, хүнсний ногооны чиглэлээр газар тариаланг хөгжүүлнэ. Хөдөө аж ахуйн газрын ашиглалтыг сайжруулах, оюуны өндөр багтаамжтай технологи нэвтрүүлэхийн тулд фермер, аж ахуй дундын хоршилтыг дэмжиж, шинжлэх ухаан, техник, технологийн үйлчилгээний албыг хөгжүүлэхийг эрмэлзэнэ.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

- Фермерийн аж ахуйн хэлбэрээр төрөлжсөн аж ахуй эрхлэхийг дэмжиж шаардагдах эдлэн газрын зарим хэсгийг хувиарлан тогтвортой эзэмшүүлж, зарим хэрэгцээгээ нийтийн ашиглалтын газраас хангаж байхаар зохицуулна.
- Зөвхөн сүүний үхрийн чиглэлийн үйлдвэрлэл хослон эрхлэх фермерийн аж ахуй байрлахыг зөвшөөрч газар олгоно.
- Нэг аж ахуйд байх үндсэн зориулалтын малын тоонд хязгаар тогтоож бусад малыг зөвхөн гэр бүлийн хэрэгцээг хангах түвшинд байлгахыг зөвшөөрнө.
- Байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

II. ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

II.1. Хүн амын өсөлт, нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээ, хот байгуулалтын ерөнхий үнэлгээ

II.1.1. Хүн амын өсөлт

Дархан-Уул аймгийн хувьд хот тосгон бусад суурин газруудад хот байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүд хийгдсэн байсан бөгөөд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад уг ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнүүдийг харгалзан хээрийн судалгааны үе шатанд сумдаас авсан саналуудыг нэмэлтээр тусган боловсруулав.

Дархан-Уул аймгийн сумдууд хүн амын хувьд бүгд 3000-с дээш хүн амтай бөгөөд хамгийн бага хүн амтай сум нь Орхон сум/3155/ бөгөөд хамгийн их хүн амтай сум нь улсын хэмжээний хот болох Дархан сум /79938/ байна. Төлөвлөлтийн жилүүд дэх өсөн нэмэгдэх хүн амын тоо, түүнд шаардлагатай нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээг статистикийн ерөнхий газрын тооцоололд үндэслэн гаргав.

Хувилбар-1. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын тоо, насны бүлгээр /төрөлтийн дундаж бууралттай байхаар статистикийн ерөнхий газрын тооцоололоор/ Хүснэгт №27

Нас/он	Аймгийн нийт дүн			Дархан сум			Орхон сум			Шарын гол сум			Хонгор сум		
	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020
Бүгд	104,426	102,125	99,058	85105	83230	80730	3656	3577	3469	9086	8884	8619	6579	6434	6240
0-4	7,138	7,733	8,625	5817	6302	7030	250	271	302	621	673	750	450	487	543
5-9	7,706	8,606	8,953	6281	7014	7297	270	301	313	670	749	779	485	542	564
10-14	8,680	9,049	9,464	7074	7375	7714	304	317	331	755	787	823	547	570	596
15-19	9,136	9,591	6,761	7445	7817	5510	320	336	237	795	834	588	576	604	426
20-24	9,186	6,273	7,730	7486	5112	6299	322	220	271	799	546	673	579	395	487
24-29	5,656	6,983	8,159	4610	5692	6649	198	244	286	492	607	710	356	440	514
30-34	6,654	7,729	8,524	5423	6299	6947	233	271	298	579	672	742	419	487	537
35-39	7,592	8,340	7,333	6187	6797	5976	266	292	257	661	726	638	478	525	462
40-44	8,221	7,219	6,914	6700	5883	5634	288	253	242	715	628	602	518	455	436
45-49	7,090	6,773	6,590	5778	5520	5371	248	237	231	617	589	573	447	427	415
50-54	6,574	6,368	5,933	5358	5190	4835	230	223	208	572	554	516	414	401	374
55-59	6,092	5,643	5,216	4965	4598	4250	213	198	183	530	491	454	384	356	329
60-64	5,242	4,831	3,824	4273	3938	3116	183	169	134	456	420	333	330	304	241
65-69	4,284	3,392	2,118	3491	2764	1727	150	119	74	373	295	184	270	214	133
70-74	2,839	1,761	1,306	2314	1435	1064	99	62	46	247	153	114	179	111	82
75-79	1,363	999	855	1110	814	697	48	35	30	119	87	74	86	63	54
80+	973	835	753	793	680	614	34	29	26	85	73	66	61	53	47

Дээрхи тооцоолол хүн амын төрөлт дундаж бууралттай байх нөхцөлд тооцоологдсон байгаа бөгөөд 2030 он гэхэд сургуулийн өмнөх боловсролын болон бага боловсролын насны хүүхдийн тоо 14844, дунд болон ахлах ангийн насны хүүхдийн тоо 17816, дээд боловсролын насны хүүхэд 9186, хөдөлмөрийн насны иргэдийн тоо 47879, тэтгэвэрийн насны иргэдийн тоо 14701 байхаар байна.

Хувилбар-2. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын тоо, насны бүлгээр /Статистикийн ерөнхий газрын тооцоололд тулгуурласан ба төлөвлөлтийн жилүүдэд уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжлөөс хамааран хүн амын шилжин явалт саарах, шилжин ирэлт нэмэгдэхээр тооцсон/ Хүснэгт №28

Нас/он	Аймгийн нийт дүн			Дархан сум			Орхон сум			Шарын гол сум			Хонгор сум		
	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020	2030	2025	2020
Бүгд	125,311	113,358	104,010	102,160	92,413	84,791	4,375	3,961	3,634	10,892	9,852	9,041	7,884	7,132	6,544
0-4	8,563	8,582	9,062	6980	6995	7388	299	300	317	745	747	787	539	540	570

5-9	9,244	9,551	9,400	7537	7785	7663	323	334	328	803	831	817	581	601	592
10-14	10,423	10,042	9,935	8498	8186	8099	364	351	347	905	873	864	656	632	625
15-19	10,965	10,645	7,109	8938	8678	5797	383	372	248	953	925	617	691	670	447
20-24	11,021	6,964	8,114	8983	5676	6613	386	244	284	958	606	706	694	438	511
24-29	6,785	7,749	8,568	5531	6318	6984	237	270	300	590	673	745	427	488	539
30-34	7,992	8,576	8,949	6517	6991	7295	279	300	312	694	745	779	502	540	563
35-39	9,119	9,265	7,707	7434	7554	6284	319	324	269	793	805	669	573	582	485
40-44	9,862	8,011	7,258	8039	6530	5915	345	280	254	857	697	632	621	504	457
45-49	8,516	7,516	6,917	6943	6127	5639	297	263	242	740	653	601	536	473	435
50-54	7,886	7,086	6,227	6429	5780	5076	275	247	218	686	614	541	496	445	392
55-59	7,307	6,261	5,475	5957	5103	4462	255	219	192	635	544	476	460	395	345
60-64	6,288	5,361	4,013	5127	4371	3271	219	187	140	547	466	349	395	337	253
65-69	5,138	3,763	2,222	4189	3067	1813	179	132	77	447	327	193	323	237	139
70-74	3,404	1,955	1,370	2776	1595	1117	118	68	48	296	169	119	214	123	86
75-79	1,633	1,106	895	1331	903	731	57	38	31	142	96	77	103	69	56
80+	1,165	925	789	951	754	644	40	32	27	101	81	69	73	58	49

Хувилбар 2-т 2020 он гэхэд хүн амын шилжилт хөдөөлгөөний эрчмийг сааруулж шилжин явалтыг 50 орчим хувиар буурч, шилжин ирэлтийг 20 орчим хувиар нэмэгдсэн байхаар тооцсон бөгөөд, төлөвлөлтийн дараагийн жилүүдэд шилжин явалт буурсаар 2030 он 5-10 хувьд хэдбэлзэнэ. Харин шилжин эрэлт одоогийн эрчмээсээ 70 орчим хувиар нэмэгдсэн байхаар тооцсон нь нэлээд өндөр үзүүлэлт юм. Дээрхи тооцоололоос харахад Дархан-Уул аймгийн хүн ам 2030 он гэхэд 125311 болж нэмэгдэх магадлалтай бөгөөд энэхүү өсөлтөд хүрч чадах эсэх нь төлөвлөлт хэрэгжих жилүүд дэх орон нутгийн хөгжил, нийгэм эдийн засгийн байдал, үйлдвэрлэл, ажлын байр гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөлөлөөс хамааралтай байна.

II.1.2. Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээ, шаардагдах газрын хэмжээ

Хэрэгцээт байдлын үнэлгээний тоон шинжилгээ

Газар зохион байгуулалтын 2016-2030 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд хот байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага, төлөвлөлтийн норм ба дүрмийн дагуу тухайн хот, сум, суурины төвийн барилга байгууламж, нутаг дэвсгэрийн бүсүүдэд шаардагдах газрын хэмжээг тооцоолж гаргалаа. Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний тооцооны үндэс болох хүн амын хэтийн тоог 2016-2020, 2021-2025, 2026-2030 оноор тооцоолж хүн амын тоотой уялдуулан орон сууц, цэцэрлэг сургууль эмнэлэг, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудын хүчин чадал, шаардагдах эдэлбэр газрын хэмжээг тодорхойлов.

/Хот байгуулалтын нормоор/

Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүс

Захиргаа олон нийтийн төвд нутгийн захиргаа олон нийтийн 7-8 байгууллага төвлөрөх бөгөөд төлөвлөлтийн хугацаанд одоогийн хэмжээнээс багасахгүй ба баг хорооны захиргаа, олон нийтийн бусад байгууллагууд бага хэмжээгээр нэмэгдэхээр төлөвлөв. Худалдаа үйлчилгээний төвд дэлгүүр, ахуйн үйлчилгээний байгууллагууд байрлаж 1,2-15,4 га газартай байна.

Гэр орон сууцны газар

Орон сууцны бүсэд шаардагдах газрын хэмжээг гаргахдаа нэг өрхөд 0,07-0,08 га эдэлбэр газар ногдохоор, өмчлөлд шаардагдах газрын хэмжээг хуулийн дагуу нэг иргэнд 0,35-0,5 га-аар тус тус тооцсон. Цэцэрлэгийн 1 хүүхдэд 40м², ерөнхий боловсролын сургууль дотуур байрт 2,0-2,8 га, эмнэлэгийн 1 оронд 300м², биеийн тамир спортын цогцолбор нь 1000 хүнд 0,7-0,9 га байна.

Үйлдвэр аж ахуйн газар

Үйлдвэр аж ахуйн бүсийн тооцоонд тухайн сумын газрын нэгдмэл сангийн тайлан, хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан үзсэн болно. Энэ бүсэд байх хүнс, бараа, барилгын материал, түүхий эдийн захуудыг хот төлөвлөлтийн нормд заагдсан 1000 хүнд 60-300м² эдэлбэр газар ногдохоор, дахин ашиглах түүхий эд /хоёрдогч түүхий эд/-ийн цэгийн газрын хэмжээг 5-6 мянган хүнд 0,1 га эдэлбэр газар бүхий 1 объект байх.

Нийтийн эзэмшлийн бусад газар

Хот орчмын бүсэд хамаарах хог хаягдлын газрын хэмжээ нь нормоор 1000 хүнд 0,02-0,05 га байна. Оршуулгын газрын хэмжээ нь нормоор 1000 хүнд 0,3-0,5 га байх ёстой боловч одоо байгаа хэмжээнээс нь ихгүй байхаар тооцсон. Авто засварын газар 100 машинд 5,0 га, шатахуун түгээх станц 2 резервуартай үед 0,1 га, 4 резервуартай бол 0,2 га, 6 резервуартай бол 0,3 га байна. Галын депо нь 5-6 мянган хүнд 0,3-0,6 га эдэлбэр газар бүхий 1 объект байх бөгөөд 2-оос цөөнгүй машинтай байна.

Автовокзал нь 100 машинд 2,3 га, 200 машинд 3,5 га эдэлбэр газартай байна. Нисэх буудлын эдэлбэр газрыг сум бүрт онцгой байдлын үед онгоц нисэх буух зурвас байхаар тооцсон бөгөөд зурвас газрын хэмжээ 0,2га байна. Сумын төвд байх халаалтын зуух, ус хангамжийн эх үүсвэр, бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг хүчин чадалтай нь уялдсан нормоор бодож төлөвлөв. Хот төлөвлөлтийн норм нь хот байгуулалтын үр ашиг, оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг хангах оновчтой хэмжээ тул түүнийг баримтлан хот байгуулалтын үйл ажиллагаа явуулах нь зохистой.

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2020 он/ хот байгуулалтын нормоор /хүн амын өсөлтийн хувьлбар 1-ээр тооцсон/

Хүснэгт №29

Бүс	Ашиглалтын бүс		Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2020он/			80730	3469	8619	6240	99058.00
Үндсэн бүс	Суурьшлын бүс	Гэр. орон сууцны газар	24202.85	1734.50	4309.50	3120.00	33366.85
		Соёл үйлчилгээ	253.31	10.87	27.24	18.76	310.17
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30
		Зам гудамж	93.50	1.60	2.10	1.80	99.00
		Ногоон байгууламж	60.55	1.73	4.31	3.12	69.71
Нөөц			1252.21	81.59	202.52	146.47	1682.79
Суурьшлын бүсийн дүн			25877.81	1831.49	4548.87	3291.65	35549.82
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10
	Аж ахуй үйлдвэрийн бүс	Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30
		Үйлдвэрийн бүс	Тусгайлан тооцоогүй				
		Хүнсний зах	2.70	0.10	0.10	0.10	3.00
		Ахуй үйлчилгээ барааны зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Барилгын материалын зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түлшний зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түүхий эдийн зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		ШТС	0.90	0.01	0.01	0.01	0.93
	Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/	Амралт сувиллын газар	8.90				8.90
		Нисэх буудал	0.20	0.20	0.20	0.20	0.80
		Хог хаях газар	1.80	0.20	0.50	0.30	2.80
		Оршуулгын газар	25.5	2.00	5.0	3.5	2.00
Зам		15.80	6.50	6.50	6.50	35.30	
Дэд бүсийн дүн			104.60	17.81	19.99	16.31	158.71

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2020он/

Хүснэгт №30

Д/Д	Сумдын нэр	2020 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	28.12	102.61	21.80	72.66	5.10	23.03	253.31
	Орхон	1.21	4.41	0.94	2.43	0.90	0.99	10.87
	Шарын гол	3.00	10.95	2.33	6.03	2.45	2.48	27.24
	Хонгор	2.17	7.93	1.68	4.37	0.90	1.71	18.76

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2025 он/ хот байгуулалтын нормоор /хүн амын өсөлтийн хувьлбар 1-ээр тооцсон/

Хүснэгт №31

Бүс	Ашиглалтын бүс		Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн	
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2025он/			83230	3577	8884	6434	102125	
Үндсэн бүс	Суурьшлийн бүс	Гэр. орон сууцны газар	25077.85	1788.50	4442.00	3217.00	34525.35	
		Соёл үйлчилгээ	262.59	11.25	28.17	19.44	321.44	
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30	
		Зам гудамж	93.50	1.60	2.10	1.80	99.00	
		Ногоон байгууламж	62.42	1.79	4.44	3.22	71.87	
		Нөөц	1252.21	81.59	202.52	146.47	1682.79	
Суурьшлийн бүсийн дүн			26763.97	1885.92	4682.43	3389.42	36721.75	
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70	
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00	
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10	
	Аж ахуй үйлдвэрийн бүс	Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50	
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38	
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30	
		Үйлдвэрийн бүс	Тусгайлан тооцоогүй					
		Хүнсний зах	2.70	0.10	0.10	0.10	3.00	
		Ахуй үйлчилгээ барааны зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Барилгын материалын зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Түлшний зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Түүхий эдийн зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		ШТС	0.90	0.01	0.01	0.01	0.93	
		Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/	Амралт сувиллын газар	8.90				8.90
	Нисэх буудал		0.20	0.20	0.20	0.20	0.80	
	Хог хаях газар		1.80	0.20	0.50	0.30	2.80	
	Оршуулгын газар		25.5	2.00	5.0	3.5	2.00	
	Зам		15.80	6.50	6.50	6.50	35.30	
	Дэд бүсийн дүн			104.60	17.81	19.99	16.31	158.71

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2025он/

Хүснэгт №32

Д/Д	Сумдын нэр	2025 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	25.21	111.03	22.47	74.91	5.10	23.87	262.59
	Орхон	1.08	4.77	0.97	2.50	0.90	1.02	11.25
	Шарын гол	2.69	11.85	2.40	6.22	2.45	2.56	28.17
	Хонгор	1.95	8.58	1.74	4.50	0.90	1.77	19.44

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2030 он/ хот байгуулалтын нормоор /хүн амын өсөлтийн хувьлбар 1-ээр тооцсон/

Хүснэгт №33

Бүс	Ашиглалтын бүс		Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн		
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2030он/			85105	3656	9086	6579	104426		
Үндсэн бүс	Суурьшлийн бүс	Гэр. орон сууцны газар	25734.10	1828.00	4543.00	3289.50	35394.60		
		Соёл үйлчилгээ	255.18	11.02	27.40	18.94	312.54		
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30		
		Зам гудамж	94.20	1.60	2.10	1.80	99.70		
		Ногоон байгууламж	63.83	1.83	4.54	3.29	73.49		
		Нөөц	1252.21	81.59	202.52	146.47	1682.79		
Суурьшлийн бүсийн дүн			27414.92	1925.24	4782.76	3461.50	37584.42		
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70		
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00		
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10		
		Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50		
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38		
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30		
	Үйлдвэрийн бүс			Тусгайлан тооцоогүй					
	Хүнсний зах			2.70	0.10	0.10	0.10	3.00	
	Ахуй үйлчилгээ барааны зах			2.10	0.10	0.20	0.10	2.50	
	Барилгын материалын зах			2.10	0.10	0.20	0.10	2.50	
	Түлшний зах			2.10	0.10	0.20	0.10	2.50	
	Түүхий эдийн зах			2.10	0.10	0.20	0.10	2.50	
	ШТС			0.90	0.01	0.01	0.01	0.93	
	Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/			Амралт сувиллын газар	8.90				8.90
				Нисэх буудал	0.20	0.20	0.20	0.20	0.80
				Хог хаях газар	1.80	0.20	0.50	0.30	2.80
				Оршуулгын газар	25.5	2.00	5.0	3.5	2.00
				Зам	15.80	6.50	6.50	6.50	35.30
	Дэд бүсийн дүн			104.60	17.81	19.99	16.31	158.71	

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2030он/

Хүснэгт №34

Д/Д	Сумдын нэр	2030 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	23.27	104.00	22.98	76.59	5.14	23.20	255.18
	Орхон	1.00	4.47	0.99	2.56	1.00	1.00	11.02
	Шарын гол	2.48	11.10	2.45	6.36	2.51	2.49	27.40
	Хонгор	1.80	8.04	1.78	4.61	1.00	1.72	18.94

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2020 он/ хот байгуулалтын нормоор /хүн амын өсөлтийн хувьлбар 2-оор тооцсон/

Хүснэгт №35

Бүс	Ашиглалтын бүс		Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2020он/			84791	3634	9041	6544	104010.00
Үндсэн бүс	Суурьшлийн бүс	Гэр. орон сууцны газар	25624.20	1817.00	4520.50	3272.00	35233.70
		Соёл үйлчилгээ	265.82	11.34	28.44	19.63	325.23
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30
		Зам гудамж	93.50	1.60	2.10	1.80	99.00
		Ногоон байгууламж	63.59	1.82	4.52	3.27	73.20
		Нөөц	1252.21	81.59	202.52	146.47	1682.79
Суурьшлийн бүсийн дүн			27314.72	1914.55	4761.28	3444.67	37435.23
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10
	Аж ахуй үйлдвэрийн бүс	Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30
		Үйлдвэрийн бүс	Тусгайлан тооцоогүй				
		Хүнсний зах	2.70	0.10	0.10	0.10	3.00
		Ахуй үйлчилгээ барааны зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Барилгын материалын зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түлшний зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түүхий эдийн зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		ШТС	0.90	0.01	0.01	0.01	0.93
	Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/	Амралт сувиллын газар	8.90				8.90
		Нисэх буудал	0.20	0.20	0.20	0.20	0.80
		Хог хаях газар	1.80	0.20	0.50	0.30	2.80
		Оршуулгын газар	25.5	2.00	5.0	3.5	2.00
		Зам	15.80	6.50	6.50	6.50	35.30
	Дэд бүсийн дүн			104.60	17.81	19.99	16.31

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2020он/

Хүснэгт №36

Д/Д	Сумдын нэр	2020 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	29.55	107.80	22.89	76.31	5.10	24.17	265.82
	Орхон	1.27	4.62	0.98	2.54	0.90	1.03	11.34
	Шарын гол	3.15	11.49	2.44	6.33	2.45	2.59	28.44
	Хонгор	2.28	8.32	1.77	4.58	0.90	1.78	19.63

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2025 он/ хот байгуулалтын нормоор / хүн амын өсөлтийн хувьлбар 2-оор тооцсон /

Хүснэгт №37

Бүс	Ашиглалтын бүс		Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2025он/			92413	3961	9852	7132	113358
Үндсэн бүс	Суурьшлын бүс	Гэр. орон сууцны газар	28291.90	1980.50	4926.00	3566.00	38764.40
		Соёл үйлчилгээ	290.89	12.35	30.95	21.44	355.64
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30
		Зам гудамж	93.50	1.60	2.10	1.80	99.00
		Ногоон байгууламж	69.31	1.98	4.93	3.57	79.78
Нөөц		1252.21	81.59	202.52	146.47	1682.79	
Суурьшлын бүсийн дүн			30013.21	2079.22	5169.70	3740.78	41002.91
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10
	Аж ахуй үйлдвэрийн бүс	Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30
		Үйлдвэрийн бүс	Тусгайлан тооцоогүй				
		Хүнсний зах	2.70	0.10	0.10	0.10	3.00
		Ахуй үйлчилгээ барааны зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Барилгын материалын зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түлшний зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		Түүхий эдийн зах	2.10	0.10	0.20	0.10	2.50
		ШТС	0.90	0.01	0.01	0.01	0.93
	Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/	Амралт сувиллын газар	8.90				8.90
		Нисэх буудал	0.20	0.20	0.20	0.20	0.80
		Хог хаях газар	1.80	0.20	0.50	0.30	2.80
		Оршуулгын газар	25.5	2.00	5.0	3.5	2.00
Зам		15.80	6.50	6.50	6.50	35.30	
Дэд бүсийн дүн			104.60	17.81	19.99	16.31	158.71

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2025он/

Хүснэгт №38

Д/Д	Сумдын нэр	2025 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	27.98	123.25	24.95	83.17	5.10	26.44	290.89
	Орхон	1.20	5.29	1.07	2.77	0.90	1.12	12.35
	Шарын гол	2.99	13.15	2.66	6.90	2.45	2.81	30.95
	Хонгор	2.16	9.52	1.93	4.99	0.90	1.95	21.44

Сумын төвийн суурьшлийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2030 он/ хот байгуулалтын нормоор / хүн амын өсөлтийн хувьлбар 2-оор тооцсон /

Хүснэгт №39


Бүс	Ашиглалтын бүс	Дархан	Орхон	Шарын гол	Хонгор	Аймгийн дүн		
Төлөвлөлтийн жил дэх хүн амын тоо /2030он/		102160	4375	10892	7884	125311		
Үндсэн бүс	Суурьшлын бүс	Гэр. орон сууцны газар	31703.35	2187.50	5446.00	3942.00	43278.85	
		Соёл үйлчилгээ	305.20	12.97	32.30	22.49	372.95	
		Захиргаа олон нийт	15.40	1.20	3.20	1.50	21.30	
		Зам гудамж	94.20	1.60	2.10	1.80	99.70	
		Ногоон байгууламж	76.62	2.19	5.45	3.94	88.20	
		Нөөц	1252.21	81.59	202.52	146.47	1682.79	
Суурьшлын бүсийн дүн		33446.98	2287.05	5691.56	4118.20	45543.79		
Дэд бүс	Инженерийн байгууламжийн бүс	Худаг усан сан	18.00	1.00	1.50	1.20	21.70	
		Бохир ус цэвэрлэх байгууламж	24.00	4.00	6.00	4.00	38.00	
		Халаалтын зуух	5.00	0.60	0.80	0.70	7.10	
	Аж ахуй үйлдвэрийн бүс	Авто вокзал	12.00	2.10	2.30	2.10	18.50	
		Галын депо	5.10	0.60	1.08	0.60	7.38	
		Хоёрдогч түүхий эд авах цэг	1.80	0.10	0.20	0.20	2.30	
		Үйлдвэрийн бүс	Тусгайлан тооцоогүй					
		Хүнсний зах	2.70	0.10	0.10	0.10	3.00	
		Ахуй үйлчилгээ барааны зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Барилгын материалын зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Түлшний зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		Түүхий эдийн зах	2.10	0.10	0.20	0.10	2.50	
		ШТС	0.90	0.01	0.01	0.01	0.93	
		Хот орчмын бүс /төвөөс 5-15 км/	Амралт сувиллын газар	8.90				8.90
			Нисэх буудал	0.20	0.20	0.20	0.20	0.80
	Хог хаях газар		1.80	0.20	0.50	0.30	2.80	
	Оршуулгын газар		25.5	2.00	5.0	3.5	2.00	
	Зам		15.80	6.50	6.50	6.50	35.30	
	Дэд бүсийн дүн		104.60	17.81	19.99	16.31	158.71	

Нийгмийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээт газрын задаргаа /2030он/

Хүснэгт №40

Д/Д	Сумдын нэр	2030 он						
		Хүүхдийн цэцэрлэг	ЕБС	Эмнэлэг	Биеийн тамир спорт	Худалдаа үйлчилгээ	Нөөц 10%	Дүн
Шаардлагатай талбайн хэмжээ	Дархан	27.92	124.87	27.58	91.94	5.14	27.75	305.20
	Орхон	1.20	5.35	1.18	3.06	1.00	1.18	12.97
	Шарын гол	2.98	13.31	2.94	7.62	2.51	2.94	32.30
	Хонгор	2.16	9.64	2.13	5.52	1.00	2.04	22.49

Хэрэгцээт байдлын үнэлгээний Орон зайн шинжилгээ
Хот төлөвлөлтийн болон барилгажилтын норм дүрмийн дагуу Боловсролын байгууллагын үйлчлэх хүрээ 500м байх ёстой.




Таних тэмдэг

- Сумын хил
- Боловсролын үйлчилгээний хэрэглэгчидийн байршил
- Боловсролын байгууллагын үйлчлэх хүрээ
- Боловсролын үйлчилгээ шаардлагагүй газар
- Одоо байгаа боловсролын байгууллага

Зураг №13. Боловсролын байгууллагын хэрэгцээт байдлын үнэлгээний орон зайн шинжилгээ

Хот төлөвлөлтийн болон барилгажилтын норм дүрмийн дагуу эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагын /хэсгийн эмнэлэг, амбулатори зэрэг/ үйлчлэх хүрээ нь 1000м байх ёстой.




Таних тэмдэг

- Сумын хил
- Эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ
- Эрүүл мэндийн үйлчилгээний хэрэглэгчдийн байршил
- Одоо байгаа эрүүл мэндийн үйлчилгээний газар
- Орон зайн шинжилгээ хийх шаардлагагүй газар

Зураг №14. Эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээт байдлын үнэлгээний орон зайн шинжилгээ

Хот төлөвлөлтийн болон барилгажилтын норм дүрмийн дагуу иргэн ААН байгууллагын эзэмшил ашиглалтын бус цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжын үйлчлэх хүрээг тухайн цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалт, хүчин чадлаас нь хамааруулан хотын чанартай, тусгай зориулалтын, дүүргийн чанартай гэх мэтээр ангилсан байдаг ба үйлчлэх хүрээг 1-5км радиустай байхаар тусгасан байдаг.



Зураг №15. Ногоон байгууламжийн хэрэгцээт байдлын үнэлгээний орон зайн шинжилгээ

II.1.3. Хот байгуулалтын суурь нөхцлийн ерөнхий үнэлгээ болон тохиромжтой байдлын үнэлгээ

Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцлийн үнэлгээ

Хот байгуулалт, суурин газрын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Хүснэгт №41

Д/Д	Хот суурины нэр	Усан хангамж	Олон жилийн шаллаг хэвсэг	Газар чичирхил /балл/	Ул хөрс		Хөрсний усны түвшин /м/	Үерт автагдсан байдал Газрын гадаргын налуу	Далайн түвшнээс өргөгдсөн байдал /м/	Бусад
					Хөрсний төрөл	Норматив ачаалал (кг/см ²)				
Дархан-Уул аймаг										
1	Дархан	+		7			0,5-10	5	1085	Үерийн хамгаалалт
2	Шарын гол	+		7	суулт		1.1	8	920	Гуу жалга
3	Салхит	+		7				3	850	
4	Хонгор	+		7				3	850	
5	Орхон	+		7			3,0-4,0	3	750	

Хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээг олон хүчин зүйлийн шинжилгээний аргаар хийсэн ба олон хүчин зүйлийн шинжилгээний арга нь ГЗМС-н технологи дээр суурилдаг (Baban and Wan-Yusof, 2003). Судалгаа нь дараахь хоёр үе шаттай: Мэдээллийг бэлтгэх ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийх гэсэн хоёр үе шаттай: Эхний үе шатанд төлөвлөлтийн хамгийн энгийн шаардлагыг хангах суурь нөхцлийг тогтооно. Хоёрдугаар шатанд олон хүчин зүйлийн дүн шинжилгээг АНР(АНР Аналитик шатлан эрэмбэлэх математик). программыг хангамжыг ашиглан жигнэсэн дундажаар тогтооно. Суурь нөхцлийн болон хүчин зүйлийн судалгааг GDEM 30 метрийн өндрийн тоон загварын зураг болон суурь нөхцлийн болон хүчин зүйлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн share файлыг ашиглан тогтоосон.

Хотжилтонд хэрэгцээт газрын байршил тогтоох шалгуур

Хүснэгт №42

Шалгуур үзүүлэлт, өгөгдлүүд		Ач холбогдол
1	ХАА-н бүсэд байх ёсгүй	Хүнсний аюулгүй байдал
2	Ойн бүсээс хол байх	Байгаль орчин/Нөөц
3	Газрын налуу хэвгий 20 бага байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин
4	Голтой ойр боловч хамгаалалтын бүсэд биш байх	Эдийн засаг/Аюулгүй байдал/ Байгаль орчин
5	Цэвдэгтэй газар сонгохгүй байх	Байгаль орчин/эдийн засаг
6	Дархан цаазтай болон Тусгай хамгаалалттай газарт байршаагүй байх	Байгаль орчин/Нөөц
7	Байгалийн сэргээгдэх эрчим хүч ашиглах бололцоотой газарт байх (aspect)	Эдийн засаг/Байгаль орчин
8	Хөрсний тогтвортой, ургамлан бүрхэвчтэй байх	Эдийн засаг
9	Ашигт малтмалын лицензийн талбайтай давцахгүй байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин

Эх сурвалж: Baban and Wan-Yusof, 2002

Жигнэсэн хувийг олохын тулд хослуулан харьцуулах аргачлалыг ашигладаг. Доорхи жишээгээр хос харьцуулалтаар жигнэсэн хувийн хэмжээг судлаач өөрийн үнэлэмжээр зэрэглэн гаргана. Бүх төрлийн нөлөөлөл, хүчин зүйлсийг жигнэн давхцуулан эдгээрийн хоорондын хамгийн зөв, бодит хоорондын холбоог тогтооно (Brandt, 2006).

$$S = e w_i x_i$$

S = Тухайн объектийн тохиромжтой байдал

w_i = Хүчин зүйлийн жинлэсэн дундаж [Бүх хүчин зүйлийн жинлэсэн дундажийн нийлбэр нь 1 тэнцүү]


x_i = Шалгуур хүчин зүйл

Нөлөөлөл, хүчин зүйлсийн үнэлгээг гаргаж авахдаа бид Analytical Hierarchy Process (АНП) аргыг хэрэглэлээ (Strager and Rosenberger, 2006). Analytic Hierarchy Process (АНП) нь онолын хувьд нөлөөлөл хүчин зүйлсийн бодит болон таамаг мэдээллүүдийг холбон давхцуулж мэргэжлийн экспертийн харьцуулах дүн шинжилгээ юм. Харьцуулалт бол зөвхөн биологийн буюу байгалийн мэдрэмж юм. Үүнд шинжлэх ухаан техникийн талаас ямар ч хамаарал байхгүй бөгөөд зөвхөн зөн совин мэдрэмжийн үүднээс хийгддэг. (Ozdemir and Saaty, 2006). Нөлөөлөл, хүчин зүйлсийн үнэлгээний хэмжээг зөв эсэхийг сайтар шалгах шаардлагатай бөгөөд үүнийг Саатий (2006) нарын аргачлалаар тогтооно.


Суурь нөхцөлийн үнэлгээ

Constrain буюу суурь нөхцөлийн зураг гаргахад ой, тариалангийн талбай, зам шугам сүлжээ, уул уурхайн олборлолтод өртсөн газар, хот суурингийн тоон зургийг ашиглаж **Constraint буюу суурь нөхцөлийн зургийг гаргасан**. Ингэхдээсонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг давхцуулж газар шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine программ дээр хийсэн. Ингэхийн тулд суурь нөхцөлийн вектор зургуудыг **ArcToolbox- Conversion tool-Polygon to raster** командыг ашиглан Raster мэдээ болгон хөрвүүлж **Erdas Imagine-Toolbox- Model Maker- New Model** команд ашиглаж гарган авсан зургууд пикселийн утгыг үржүүлэх замаар нэгдсэн Constraint зургийг гаргасан. Үржвэрийн үр дүнд 0 утгатай гарч байгаа газруудыг тохиромжгүй гэж үзнэ. Зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн.

Хот, суурины дэвсгэр газрыг төлөвлөхөд ой бүхий газартай давхцахгүй байх, тариалангийн газартай давхцахгүй байх, уул уурхайн хүчтэй эвдрэлд өртсөн газарт биш байх, голтой ойр боловч хамгаалалтын бүсэд биш байх, одоо байгаа суурьшлын бүсэд биш байх гэсэн нөхцөлт шалгуурыг тавьсан.



Зураг №16. Суурь нөхцлийн үнэлгээний шалгууруудын зургууд



Зураг №17. Суурь нөхцлийн үнэлгээний нэгтгэл зураг

Дээрх суурь нөхцөлийн үнэлгээний нэгтгэл зургаас харахад Дархан-Уул аймгийн нийт нутаг дэвсгэрийн 36.1% буюу 67073.9 га талбай нь хот суурин газар, ой, газар тариалан, усан сан бүхий газар, уул уурхайн зориулалтаар ашиглагдаж байна.

Хүчин зүйлийн үнэлгээ


Тохиромжтой байдлын үнэлгээнд олон хүчин зүйл ашиглаж байгаа (factor) үед энэ аргыг хэрэглэнэ. Олон хүчин зүйлүүдийг хооронд нь харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой ба эзлэх жингийн хувьд өндөр жин дарна. Шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэхдээ АНР (analytical hierarchy process) буюу шатлан захирах дүн шинжилгээний аргыг ашигласан (Saaty 1977). Энэ арга нь шалгуур үзүүлэлтийн эрэмбэлэлтийн матрицаар жингийн утгыг тодорхойлдог. Сонгон авсан хүчин зүйлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэлтийн матрицыг ашиглан жингийн утгыг тодорхойлохын тулд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлийг хот, суурины дэвсгэр газрын тохиромжтой байдалд нөлөөлөх ач холбогдлоор эрэмбэлсэн. Эцэст нь Шинээр байгуулагдах хот, суурины дэвсгэр газарт өгөх байгалийн нөхцөл, нөөцийн нэгдсэн үнэлгээг гаргахдаа дээр тооцон гаргасан хүчин зүйлийг ач холбогдлоор нь дараах байдлаар эрэмбэлж хүчин зүйл бүрт харгалзах жингийн хувийг АНР буюу эрэмбэлэлтийн матрицын аргаар тооцож гарсан.

Хот суурин газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь

Хүснэгт №43

№	Хүчин зүйл	Эрэмбэ	Харьцангуй жин
1	Газрын гадаргын налуу	1	0.0807
2	Хөрсний тогтвортой байдал /цэвдэг болон гүний усны түвшин/	2	0.1159
3	Ургамлын бүрхэц	3	0.1731
4	Зам хүртэлх зай /Төмөр зам болон авто зам хүртэлх зай/	4	0.2215
5	Налуугийн чиглэл буюу зүг зовхис	5	0.3071
6	Гадаргын өндөршил	6	0.0582
7	Гүний ус	7	0.0435
CR=0.0207			


Дээрх эрэмбэлэлтээс хамгийн ач холбогдолтой нь газрын гадаргын налуу болон хөрсний тогтвортой байдал, хамгийн ач холбогдол багатай нь хөрсний гүний усний түвшин гэж тооцоод хүчин зүйлүүдийг эрэмбэлсэн. Эрэмбэлэлтийн матрицаар тооцон гаргасан жингийн утга хэр зэрэг үнэнд нийцэж байгаа consistency ratio буюу нийцлийн харьцааны индексээр тооцож үзэхэд 0,0207 байгаа нь хүчин зүйлийн хоорондын харьцаа зохицол сайтай болох нь батлагдаж байна.




Зураг №18. Хүчин зүйлийн үнэлгээний зургууд

Хүчин зүйлүүдийн үнэлгээний үр дүнг нэгтгэн нэгдсэн үнэлгээний зургийг гаргахдаа сонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг

давхцуулж шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine программ дээр хийсэн.




Ингэхийн тулд хүчин зүйлийн үнэлгээний зургуудыг **Erdas Imagine-Toolbox-Model Maker- New Model** команд ашиглаж *тухайн объектийн тохиромжтой байдлын үнэлгээг хүчин зүйлийн жинлэсэн дундаж* утгаар үржүүлж хооронд нь нэмэх замаар нэгдсэн **хүчин зүйлийн үнэлгээний** зургийг гарган авч зурагласан.



Зураг №19. Хот суурин газрын тохиромжтой байдлын хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зураг

Дээрхи хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслийн тусламжтайгаар бүх зургийг 0-255 хооронд утга авахуулж засвар хийж зурагласан бөгөөд өндөр утга авах тусам маш тохиромжтой, бага утга авах тусам хот суурин байгуулахад нэн тохиромжгүй газар нутаг юм.

Хот суурин газрын тохиромжтой байдлын суурь нөхцлийн болон хүчин зүйлүүдийн нэгдсэн зургийг **Erdas Imagine-Toolbox- Model Maker- New Model** командын тусламжтайгаар нэгтгэн зурагласан.



Зураг №20. Хот суурин газрын тохиромжтой байдлын хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний ангиллын зураг

Хот суурин газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зургийг тохиромжтой байдлаар нь нэн тохиромжтой, тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй гэж ангилан авч үзлээ.

Шинээр хот байгуулах газрын хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээ

Хүснэгт №44

№	Чанарын үзүүлэлт	Талбай, га	Эзлэх, %
1	Нэн тохиромжтой	49,235.17	15.36
2	Тохиромжтой	109,917.22	34.28
3	Хязгаарлагдмал тохиромжтой	94,818.03	29.57
4	Тохиромжгүй	66,648.08	20.79
5	Дүн	320,618.50	100.00

Хот суурин байгуулах газрын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс одоо ашиглагдаж байгаа газар ашиглалтын суурь нөхцлүүдийг хасаж тооцоо хийхэд Дархан-Уул аймгийн нийт нутаг дэвсгэрийн 49,64% нь хот, суурины дэвсгэр газар тохиромжтой, 29,57% нь хязгаарлагдмал тохиромжтой, 20,79% тохиромжгүй.

II.2. Хот суурин газрын газар ашиглалтын ангилал ба бүсчлэл

Дэлхий нийтээрээ дагаж мөрдөх боломжтой нэг стандарт газар ашиглалтын ангилал өнөө хэр байхгүй байна. Үүний шалтгаан нь улс орон, бүс нутаг бүрийн хөгжлийн онцлог, байгаль нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хууль тогтоомж нь харилцан адилгүй байдагтай холбоотой. Иймээс тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг мэдэрч, сайтар судалсны үндсэн дээрээс газар ашиглалтыг ангилах шаардлагатай юм. Түүнчлэн зөвхөн одоо үед ялгарч буй газар ашиглалтын хэв шинжээс гадна ойрын ирээдүйд шинээр үүсч болох газар ашиглалтын хэв шинжийг урьдчилан тооцоолж ангилалдаа оруулж болох юм. Ингэж урьдчилан тооцоолох нь газар ашиглалтын ангиллыг илүү тогтвортой, бат бөх байлгах үндэс суурь болдог. Орчин цагт газар ашиглалтыг ангилах үйл ажиллагааг дараах дэс дараалалтайгаар явуулах нь илүү тохиромжтой болсон байна.

Алхам 1. Судалгаа. Газар ашиглалтыг ангилахын тулд хамгийн эхэнд хийх ёстой ажил бол тухайн нутаг дэвсгэрийн газар ашиглалтын хэв шинжүүдийг олж илрүүлэх судалгаа юм. Үүний тулд хамгийн сүүлийн үеийн агаараас авсан ортофото болон хиймэл дагуулын зурган мэдээг ашиглана. Зайнаас тандан судлалын програм хангамжийн тусламжтайгаар дээрх зургуудыг боловсруулах, вектор дүрс файл үүсгэх замаар газар ашиглалтын хэв шинжүүдийг ялган зураглах нь судалгааны үр дүнг илүү ойлгомжтой, ашиглахад хялбар болгодог байна. Судалгааг илүү бодитой, үнэн зөв байлгах үүднээс зурган мэдээллээр олж тогтоосон газар ашиглалтын хэв шинжүүдийг явуулын судалгаагаар тодруулга хийн баталгаажуулах шаардлагатай.


Алхам 2. Боловсруулалт. Судалгааны үр дүнд олж илрүүлсэн газар ашиглалтын хэв шинжүүдийг хоорондын төсөөтэй болон уялдаатай байдлыг харгалзан бүлэглэн төрөлжүүлэх ёстой. Энэ үйл ажиллагаа нь газар ашиглалтын хэв шинжүүдийг ангилах суурийг бүрдүүлэн өгч байгаа юм. Ингэж төрөлжүүлсэн газар ашиглалтын хэв шинжүүдийг нэгтгэн системжүүлэх, ангиллын зэрэглэл тогтоох боломжтой болдог. Ангиллын зэрэглэл нь ихэвчлэн 2-4 шатлалтай байдаг. Харин

ангиллын шатлал хэт ерөнхий болон дэлгэрэнгүй байх нь газар ашиглалтыг хянах, удирдах үйл явцыг сулруулах талтайг анхаарах хэрэгтэй. Нэгэнт бий болсон газар ашиглалтын ангиллыг аливаа хууль, тогтоомж болон бусад практик хэрэглээнд нэвтрүүлэхийн тулд зайлшгүй кодчилон нэршлийн тэмдэглэгээг хураангуйлах шаардлагатай болдог байна. Сүүлийн үед дэлхийн өндөр хөгжилтэй орнууд ингэж кодчилох нь түгээмэл болжээ. Зарим орнуудад газар ашиглалтын ангилал, кодыг тодорхой өнгөний кодтой холбон түүнийгээ эрх зүйн орчноор баталгаажуулж өгсөн нь газар ашиглалтын зураглал явуулахад илүү тохиромжтой, боловсронгуй нөхцөлийг бүрдүүлжээ.

Алхам 3. Хяналт. Боловсруулсан газар ашиглалтын ангиллыг хянаж, шалгана гэдэг нь харьцангуй ойлголт юм. Учир нь газар ашиглалтын хэв шинжүүд техник, технологийн хөгжил, улс орны нийгэм эдийн засгийн онцлогоос хамааран байнга өөрчлөгдөж байдаг билээ. Энэ газар ашиглалтын ангиллыг хяналтгүй орхино гэсэн үг биш юм. Хэр зэрэг бодитой, сайн болсоныг нь үнэлж дүгнэхийн тулд гадны бусад орны газар ашиглалтын ангилалтай харьцуулан судлах шаардлагатай. Харьцуулсан судалгаа нь нэгдүгээрт өөрийн улс орны нөхцөл байдалтай ойролцоо үзүүлэлттэй гадаадын орнуудын газар ашиглалттай харьцуулан үзэх, хоёрдугаарт газар ашиглалтын ангилал нь харьцангуй өндөр үр дүн үзүүлж буй гадаадын орнуудтай харьцуулан үзэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Ингэж харьцуулан үзэж, гарсан асуудлуудыг нэгтгэн шийдэж илүү боловсронгуй болгох замаар газар ашиглалтын ангилалыг цаашид хөгжүүлж болох юм. Ерөнхийдөө газар ашиглалтын ангилалын хувьд баруун европын орнууд, скандинавын хойгийн орнууд, зүүн азийн орнууд болон АНУ-ын ангилалууд нь илүү сайн, боловсронгуй болсон гэж судлаачид үздэг.

Алхам 4. Хэрэгжилт. Газар ашиглалтын ангиллыг үр дүнтэй болгох, практикт нэвтрүүлэх нь газрын менежмент, хот төлөвлөлтийг дэмжих маш чухал нөхцөл юм. Иймээс газар ашиглалтын ангиллын эрх зүйн орчныг бий болгох, хэрэгжилтийг хангах бусад нийгэм, эдийн засгийн хөшүүрэгтэй хослуулах нь илүү үр дүнтэй.

1. Газар ашиглалтыг ангилал аргагүй



Судалгааны явцад гадаадын газар ашиглалтын ангилал, тэдгээрийн хувьсал өөрчлөлт, урьд нь энэ талаар явуулж байсан судалгаа шинжилгээний ажлуудыг харьцуулан нэгтгэх замаар бид өөрийн оронд тохиромжтой газар ашиглалтын ангиллыг бий болгох зорилго тавьсан юм. Тус судалгааны хүрээнд бидний боловсруулсан газар ашиглалтын ангилал нь ерөнхий ба дэд бүсчлэлтэй, хот суурины түүхэн үе шат болон ирээдүйн өөрчлөлтийг харгалзаж үзсэн харьцангуй уян хатан зүй тогтол бүхий ангилал болсон болно (ангиллыг доор жагсаалтаар үзүүлэв). Цаашид энэ ангилал дээр тулгуурлан функциональ бүсчлэлийг явуулах боломжтой.


Газар ашиглалтын ангилал

Хүснэгт №45

Үндсэн бүс	д/д	Дэд бүс
Сууцны бүс	1	Хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс
	2	Нам давхрын орон сууцны бүс
	3	Дунд давхрын орон сууцны бүс
	4	Өндөр давхрын орон сууцны бүс
	5	Гэр хороолол
Олон нийт, ажил хэргийн төв бүс	6	Хотын олон нийт, ажил хэргийн төв бүс
	7	Хотын олон нийт, ажил хэргийн дэд бүс
	8	Хорооллын худалдаа, ажил хэргийн бүс
	9	Үйлчилгээний төрөлжсөн бүс
	10	Тээвэр, бөөний худалдаа, агуулахын бүс
	11	Хөнгөн үйлдвэрийн бүс
Үйлдвэрийн бүс	12	Тусгай үйлдвэрийн бүс
Ногоон байгууламжийн бүс	13	Ногоон байгууламж задгай талбай
	14	Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн бүс
Холимог ашиглалтын бүс	15	Үйлдвэр, сууцны холимог бүс
	16	Худалдаа, үйлдвэр, сууцны холимог бүс
	17	Үйлдвэр, худалдааны холимог бүс
Инженерийн шугам сүлжээ, зам тээврийн бүс	18	Инженерийн шугам сүлжээний бүс
	19	Инженерийн барилга байгууламжийн бүс
	20	Гудамж, зам тээврийн бүс
Г.Цэдэндашийн Моностойн аманд нарсны тарьцаар ойжуулсан талбайнууд нь өдгөөийн санд шилжсэн байна. Ойн хэлбэрийн хувьд ихэвчлэн энгийн ой байх ба хөгшин моддын доогуур залуу модод ташинги үүсгэж нийлмэл ойг бий болгосон байдаг. Тухайн бүс нутагт Монгол оронд ургадаг нарс, хус, улиангар, бургас зэрэг модод тархан ургадаг ба тармаг байдлаар бага хэмжээний талбайд хайлаасан ой ургасан байдаг.

Тус нутаг дэвсгэрт хусан ой зонхилох ба дан бүрэлдэхүүнтэй нарс, хус-нарс, нарс-хусан ой харилцан адилгүйгээр тархан ургаж, цэвэр ба холимог ойг үүсгэсэн байна. Дархан аймгийн ойн сангийн нийт талбайгаас Хонгор сум 77623 га, Орхон ум 3271 га, Шарын гол сум 914 га, Дархан сум 189 га-г тус тус эзэлдэг

Дархан-Уул аймгийн ойн сангийн талбай (га) /газрын төрлөөр/

Хүснэгт №64

Сумын нэр	Ойгоор бүрхэгдсэн				Ойгоор бүрхэгдээгүй							Ойн галбайн дүн	Ойн бус талбай					Ойн бус талбайн дүн	Бүх талбай
	Байгалийн ой	Сөөг торлог	Таримал ой	Дүн	Тармаг	Шатсан талбай	МБ талбай	Ойжих талбай	хшөн талбай	Дүн	Цагаан өнгөр		Нуур гол	хэот	Таг царам	Түймрийн зурвас			
Аж ахуйн төрөл Хамгаалалтын бүсийн ой - Ногоон бүс																			
Шарын гол	798	0	0	798	87	0	0	29	0	116	914	0	0	0	0	0	0	914	
Дүн	798	0	0	798	87	0	0	29	0	116	914	0	0	0	0	0	0	914	
Аж ахуйн төрөл Хамгаалалтын бүсийн ой-Хориотой зурвасын ой																			
Орхон	921	0	0	921	2042	0	0	285	15	2342	3263	8	0	0	0	0	0	8	3271
Хонгор	55253	1149	79	56481	3166	673	249	1981	0	6069	62550	4150	0	96	0	0	0	4246	66796
Дархан	0	0	0	0	189	0	0	0	0	189	189	0	0	0	0	0	0	0	189
Дүн	56174	1149	79	57402	5397	673	249	2266	15	8600	66002	4158	0	96	0	0	0	4254	70256
Аж ахуйн төрөл Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр өнгөр төгөл ой																			
Хонгор	7833	143	0	7976	1668	43	52	819	0	2582	10558	269	0	0	0	0	0	269	10827
Дүн	7833	143	0	7976	1668	43	52	819	0	2582	10558	269	0	0	0	0	0	269	10827
Нийт дүн	64805	1292	79	66176	7152	716	301	3114	15	11298	77474	4427	0	96	0	0	0	4523	81997

* Эх үүсвэр: /Ойн хайгуул ХХК, Ой зохион байгуулалт 2013/


Ойн сангийн өөрчлөлт

Дархан-Уул аймгийн ойгоор бүрхэгдсэн талбайн 64805 га -г байгалийн ой, 1292 га -г бут сөөг, 79га-г таримал ой, ойгоор бүрхэгдээгүй талбайн 7152 га-г тармаг ой, 716 га-г шатанги, 301 га-г мод бэлтгэсэн талбай, 3114га-г ойжих талбай тус тус эзэлж байгаа ба ойн сангийн талбай өөрчлөлтийг 2004-2013онд /ой зохион байгуулалт хийгдсэн онтой харьцуулахад/ хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулахад доорх байдалтай байна.

Дархан-Уул аймгийн ойн сангийн талбайн өөрчлөлт(2004-2013он)

Хүснэгт №65


Ойн талбай (га)								Ойн бус талбай		Ойн сангийн нийт талбай
Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй					Цагаан энгэр	ХЭОТ	
Байгалийн ой	Сөөг	Таримал ой	Тармаг	Шатанги	МБТ	Ойжих	ХШӨН талбай			
61672	2458	-	5983	832	1198	3979	-	2877	-	79012
64805	1292	79	7152	716	301	3114	15	4427	96	81997
+3133	-1166	+79	+1169	-116	-897	-865	+15	+1550	+96	+2985



Зураг №35. Ойн сангийн өөрчлөлт

2013 оны ой зохион байгуулалтын ажлын үр дүнд тус аймгийн ойн сангийн нийт талбайг 81997 га гэж тогтоосон. Үүнийг 2004 оны ой зохион байгуулалтын дүнтэй харьцуулж үзэхэд 2985 га талбайгаар нэмэгдсэн дүнтэй гарч байна. Дээрх хүснэгтээс үзэхэд бут сөөг 1166 га-р багассан боловч таримал ой 79 га-р, байгалийн ой 3133га-р нэмэгдэж, ойгоор бүрхэгдсэн талбай нийтдээ 2046 га-р нэмэгдсэн байна.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн хувьд тармаг ой 1169 га-р, хортон шавьж, өвчинд нэрвэгдсэн талбай 15 га-р нэмэгдэж харин шатсан ой 116 га-р, мод огтолсон талбай 897 га-р, ойжих талбай 865 га-р тус тус буурсан байна Ойн бус талбайн хувьд цагаан энгэр 1550 га-р, хөрсний эвдрэлд орсон талбай 96 га-р тус тус нэмэгдэж нийт ойн бус талбай 1646 га-р нэмэгдсэн байна.



Зураг №36. Дархан-Уул аймгийн ойн сангийн өөрчлөлт

* Эх үүсвэр: /Ойн хайгуул ХХК, Ой зохион байгуулалт 2013/

Харин шатанги, МБ талбай нь сүүлийн жилүүдэд ойн санг нөхөрлөлд эзэмшүүлсэний үр дүнд ойн түймэр хууль бус мод бэлтгэл багассан нөгөөтэйгүүр эдгээр талбай нь сүүлийн жилүүдэд хусаар эрчимтэй сэргэн ургаж байгаатай холбоотой. Ойжих талбайн хувьд өмнөх ой зохион байгуулалтын үед их хэмжээний цагаан энгэрийг ойжих талбайд хамруулан авсантай холбоотой.

Байгалийн ойн талбай, нөөц хасагдсан гол шалтгаан нь 1-рт хүний зүй бус үйл ажиллагаанаас болж удаа дараа гарч байсан ойн түймрийн учруулсан хохирол болж байна. 2-рт ойн ариун цэвэр муу байгаагаас ойн хөнөөлт шавжийн голомт арилахгүй, залуу дунд насны болон болц гүйцэж яваа ойд учруулсан хохирол их байна. 3-рт хөдөө орон нутгаас хотод шилжин ирж суурьшигчид ихэссэнээр мод, модон материалын хэрэгцээ эрс нэмэгдэн, зах зээлд мод үнэтэй болсон нь хууль бусаар мод бэлтгэх сонирхолыг төрүүлж байгалийн ойд ихээхэн хохирол учруулж байна. 4-рт уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтын нөлөөгөөр гацуур болон навчит үүлдрийн модод хатаж хуурайших явдал ажиглагдаж байна. Мөн байгалийн гэнэтийн гамшиг нойтон цас, хүчтэй салхи зэрэг сөрөг хүчин зүйлс нь залуу, дунд

насны ойд илүүтэйгээр хохирол учруулж ойн ариун цэврийн байдлыг доройтуулсан байна. 5-рт ногоон бүсийн ойн сан бүхий газарт аж ахуйн нэгж байгууллагуудын зуслан ихээр баригдах болсон, хотын дэд бүтэц өргөжиж байгаагаас иргэд ойн сан бүхий газарт мод огтолж, бут, сөөг бүхий газрыг түрж эмх замбараагүй барилга байшин барьж байгаа нь “Ойн тухай” хуулийн 8.6 заалт, “Усны тухай” хуулийн 31.2.1 заалт зөрчигдөж байгаа төдийгүй ой, усны сангийн нөөцийг доройтуулж ойн нөхөн сэргэх, тэлж ургах боломжийг хааж байна.

IV.1.2. Ойн нөөц, ашиглалт

Ойн нөөц

Дархан-Уул аймгийн ойн сангийн нийт нөөц 4833063 м³ байгаагаас ойн нөөц 4618521м³, тармаг модны нөөц 172462 м³, бүлэг модны нөөц 42080 м³, хатсан модны нөөц 60935 м³, унангийн нөөц 60935 м³ байгаа ба байгалийн ойн нөөцийг аж ахуйн төрөл тус бүрээр авч үзвэл:

1. Ногоон бүсийн ой 44610м³
2. 100 га хүртэлх ой, уулын өвөр энгэрийн төгөл ой 452930м³
3. Хориотой зурвасын ой 4120981м³

Дархан-Уул аймгийн байгалийн ойн талбай, нөөц насны бүлгээр

Хүснэгт №66

Модны төрөл	Насны бүлэг								Дүн	
	Залуу ой		Дунд насны ой		Болц гүйцэж яваа ой		Болц гүйцсэн ХӨГШИН ОЙ		Талбай	Нөөц
	Талбай	Нөөц	Талбай	Нөөц	Талбай	Нөөц	Талбай	Нөөц		
Аж ахуйн төрөлХамгаалалтын бүсийн ой - Ногоон бүс										
Нарс	53	3860	180	15310	0	0	0	0	233	19170
Хус	2	60	480	21880	48	3150	0	0	530	25090
Бургас	0	0	35	350	0	0	0	0	35	350
Дүн	55	3920	695	37540	48	3150	0	0	798	44610
Аж ахуйн төрөлХамгаалалтынбүсийной - Хориотойзурвасыной										
Нарс	84	5910	4096	388650	1111	115500	4589	615770	9880	1125830
Хус	1958	51130	9213	437401	8949	589660	24332	1843330	44452	2921521
Улиангар	243	4290	538	34360	106	12000	149	9590	1036	60240
Хайлаас	0	0	5	50	0	0	0	0	5	50
Бургас	201	2640	600	10700	0	0	0	0	801	13340
Дүн	2486	63970	14452	871161	10166	717160	29070	2468690	56174	4120981
Аж ахуйн төрөлХамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой										
Нарс	77	5530	1287	113880	293	32910	43	5140	1700	157460
Хус	725	14300	2421	90860	1717	105180	1171	82910	6034	293250
Улиангар	47	940	52	1280	0	0	0	0	99	2220
Дүн	849	20770	3760	206020	2010	138090	1214	88050	7833	452930
Модны төрлөөр										
Нарс	214	15300	5563	517840	1404	148410	4632	620910	11813	1302460
Хус	2685	65490	12114	550141	10714	697990	25503	1926240	51016	3239861
Улиангар	290	5230	590	35640	106	12000	149	9590	1135	62460
Хайлаас	0	0	5	50	0	0	0	0	5	50
Бургас	201	2640	635	11050	0	0	0	0	836	13690
Нийт дүн	3390	88660	18907	1114721	12224	858400	30284	2556740	64805	4618521

Ойн нөөцийг модны төрөл тус бүрээр авч үзвэл хус 3239861м³, нарс 1302460м³, улиангар 62460 м³, бургас 13690 м³, хайлаас 50 м³ нөөцтэй байна.

Модны аж ахуйн ач холбогдлыг илэрхийлэх зорилгоор насны бүлэгт хуваадаг. Судалгаагаар тогтоосон ойн бүх нөөцийг насны бүлгээр хэрхэн тархсаныг ангилж үзвэл залуу насны ой 88660 м³, дунд насны ой 1114721м³, болц гүйцэж яваа ой 858400м³, болц гүйцсэн хөгширсөн ой 2556740м³ нөөцтэй байна. Байгалийн ойн нийт нөөцийн 2 %-ийг залуу насны ой, 24.1 %-ийг дунд насны ой, 18.5%-ийг болц гүйцэж яваа ой, 55,4%-ийг болц гүйцсэн хөгширсөн ой эзэлж байна.

Ашиглалт

1980 онд Сэлэнгэ аймгийн Ерөө, Шарын голын мод бэлтгэлийн аж ахуй байгуулагдан ойн санг олон жил ашиглажээ.

2012 онд хэрэглээний болон түлээний мод бэлтгэх тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 98 тоот тогтоолоор аймгийн хэмжээнд арчилгаа, цэвэрлэгээ явуулах замаар хэрэглээний мод 2505м.куб, түлээний зориулалтаар 4595м.куб мод бэлтгэхээр шийдвэрлэсэн бөгөөд мод бэлтгэх талбай тусгаарлалтыг 4 аж ахуйн нэгжийн 5 газарт 129 га, 23 нөхөрлөлийн ойн цэвэрлэгээний 460га талбайг тусгаарлаж, аймгийн хэмжээнд нийт 4 мэргэжлийн байгууллага нийт 1500 м.куб мод, 15 нөхөрлөл 620 м.куб мод бэлтгээд байна.

Тус аймгийн хэмжээнд 2013онд ойгоос бэлтгэх модны саналыг сумд болон мод бэлтгэх эрх бүхий байгууллагаас нэгтгэн ой зохион байгуулалтын материал, ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн БОНХЯ. “ОБХТ”УУГ-т хүргүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сум нь зах зээлийн өмнө 1980-90-ээд оны үеүдэд Ойн аж ахуй, Шарын голын МБ аж ахуй үйл ажиллагаагаа явуулж байсан учир хэрэглээний модны ашиглалт өндөр байв.

Харин зах зээлийн шилжилтийн үед дээрх үйлдвэр нь модны нөөц хомсдсон, хэрэглээний модны хэмжээнд хязгаарлалт хийсэн зэрэг шалтгаанаас өөрийн хүчин чадлаар ажиллах боломжгүй болж, үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон байна. Одоогийн байдлаар хэрэглээний модны хэмжээ буурч, түлшний зориулалтаар мод бэлтгэж ашиглаж байна. Сүүлийн жилүүдэд Дархан-Уул аймгийн болон 3 сумдын айл өрх, сургууль эмнэлэг, цэцэрлэг, засаг захиргааны байгууллагуудын түлшний хэрэгцээнд жилд дунджаар 1000м³ орчим модыг ойгоос бэлтгэсэн байна.

Дархан-Уул аймгийн хэмжээгээр бэлтгэсэн модны хэмжээ

Хүснэгт №67

Бэлтгэсэн он	Бэлтгэсэн талбай /га/	Бэлтгэсэн модны хэмжээ /м3/
2005	83	1004
2007	25	500
2008	55	654
2009	89	1241


2010	130	950
2011	130	1209
2012	131	1500
Дүн	643	7058

Дархан-Уул аймагт нийтдээ 69 нөхөрлөл 69809 га талбайг эзэмшин, хариуцан хамгаалж 2013 оны байдлаар үйл ажилгаагаа явуулж байна. Үүнд: Хонгор суманд 62 нөхөрлөл 68239 га талбайг, Шарын гол суманд 3 нөхөрлөл 1407 га, Орхон суманд 4 нөхөрлөл 163га талбайг тус тус эзэмшиж байна.

IV.2. Ойн аж ахуйн арга хэмжээний төлөвлөлт

IV.2.1. Ойн сангийн газрын менеженгийн бүс

Манай орны ой нь эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ургадаг учир түймэр, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий байдаг. Дархан-Уул аймгийн ногоон бүсийн ойн сангийн нийт талбай 81997 га бөгөөд үүний 77474 га (94.48%) талбайг ойн талбай, 4523 га (5.52%) талбайг ойн бус талбай эзэлж байна. Ойд тавих хяналт сул байгаагийн хар гайгаар хүмүүс ашиг олох зорилгоор хууль бусаар мод бэлтгэх, ойтой зүй бусаар харьцах байдлыг үүсгэж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж байна. Иймээс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөх шаардлагатай байдаг.



Зураг №37. Ойн сангийн газрын менежментийн бүс

Ойн сангийн менежментэд баримтлах үндсэн зарчим

Орон нутагт хувийн хэвшлийн ойн мэргэжлийн байгууллагуудыг олноор байгуулах, ойн санг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээгээр эзэмшүүлэх, ойн нөхөрлөл байгуулан байгаль хамгаалах ажилд нутгийн иргэдийн оролцоог дээшлүүлэх нь ойн сангийн газрын менежментийн гол зарчим байна.

Ойн сангийн газрын менежментийн бүсүүд

Ойн нөхөрлөл, иргэдийн эзэмшлийн бүс 69809 га

Хамтын эзэмшлийн ойн аж ахуй нь манай орны ойн салбарын хувьд менежментийн цоо шинэ үзэл баримтлал юм. Хамтын эзэмшлийн ойн аж ахуйг эрхлэн хөтлөх үндсэн нэгж нь нутгийн иргэдээс бүрдсэн ой хамгаалах иргэдийн нөхөрлөл юм. Ойн нөхөрлөлд ойн санг гэрээгээр эзэмшүүлэх замаар ойг хамгаалах асуудал өдөр ирэх тутам төр засгийн бодлого, чиг үүрэг болсоор байна. Дархан-Уул аймагт нийтдээ 69 нөхөрлөл 69809 га талбайг эзэмшин, хариуцан хамгаалж 2013 оны байдлаар үйл ажилгаагаа явуулж байна. Үүнд: Хонгор суманд 62 нөхөрлөл 68239 га талбайг, Шарын гол суманд 3 нөхөрлөл 1407 га, Орхон суманд 4 нөхөрлөл 163 га талбайг тус тус эзэмшиж байна.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

Тухайн орон нутгийн хороо, хэсгийн иргэдийн ойн хамтын нөхөрлөл, иргэдэд 15 хүртэлх жилээр газар ашиглуулж, ойн нөөцийг эзэмшүүлэн ойг хамгаалах, ойн дагалт баялгийг ашиглах, ой зохион байгуулалт хийх, экотуризм, зөвшөөрөгдөх мод бэлтгэл явуулах /унанги болон хөгшин модыг гэрэлтүүлэг, цэвэрлэгээний зориулалтаар/ эрхийг нутгийн иргэдэд олгоно.

Хамгаалалтын бүсийн ой-21226.336га

Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын ой, сургалт, судалгааны зориулалттай ой, нийслэл болон бусад хот, суурингийн ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс дээш налуу газрын ой хамрахаар заасан байдаг.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялагийг ашиглахаас бусад үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Хот, суурин газраас алслагдсан зайд оршиж байгаа ногоон бүсийн ой нь тэр бүр зориулалтаар ашиглагдахгүй, завсардан ойн аж ахуйн ба хамгаалах арга хэмжээг хэн авч явуулах нь тодорхойгүй, эзэнгүйдэх шинжтэй байдаг тул хот, тосгоны хилээс гадагш оршиж байгаа боловч тухайн хот, тосгоны ногоон бүсэд хамаарах ойн санг ойн нөхөрлөлд эзэмшүүлэх бодлогыг баримтлах нь зүйтэй юм.

IV.2.2. Ойн аж ахуйн арга хэмжээ

Ойн арчилгааны огтлолт


Ой үүсэж бий болсноос эхлээд үндсэн ашиглалтын огтлолтод орох хүртэл ойгоос авч ашиглаж буй бүх мод материалыг **завсрын ашиглалт** гэнэ. Энэ нь ихэвчлэн арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын арга, хэлбэрээр хэрэгждэг.

Арчилгааны огтлолт нь ойн бүрэлдэхүүн, түүний тоо хэмжээ болон чанарыг сайжруулах, моддын техникийн болцын насанд хүрэх хугацааг богиносгох, аж ахуйн сонирхлын үүднээс ойг бүрэн дүүрэн ашиглах зорилгоор хийгддэг ойн аж ахуйн хамгийн чухал арга хэмжээ юм.

Арчилгааны огтлолтоор дараах үндсэн зорилтыг шийдвэрлэдэг (Леса МНР, 1988). Үүнд:

- Аж ахуйн ашиг сонирхлын үүднээс ойн бүрэлдэхүүнийг зохицуулах
- Аж ахуйн шаардлагад нийцсэн ойн хэлбэрийг бий болгох
- Өвчин хортонд өртсөн болон гэмтсэн моддыг огтолсноор ойн эрүүл байх нөхцлийг сайжруулах
- Хэрэгцээний модны гарцыг нэмэгдүүлэх
- Модны техникийн болц гүйцэх хугацааг богиносгох
- Байгалийн сийрэгжих үйл явцад хорогдох моддыг урьдчилан огтолсноор ой ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх
- Байгалийн сөрөг үйлчлэл (салхи, цас)-д ойн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Түүнчлэн манай орны нөхцөлд Зүүн Хэнтийн залуу шинэсэн ойд арчилгааны огтлолтыг явуулж туршсан судалгааны ажил байдаг (Цогт, Баттулга, 2002)



Зураг №38. Ойн нөөцийн өсөлт

Арчилгааны огтлолтыг гэрэлжүүлэх, тохируулах, сийрүүлэх, завсрын гэсэн 4 хэлбэрт хуваадаг.

Тус аймгийн хэмжээнд арчилгааний огтлолт явуулах шаардлагатай нийт 2546 га талбайд 101910 м³ нөөц бүхий хус, улиан гаран ой байгаа бөгөөд арчилгааний огтлолтоор жилд 101 га талбайгаас 4076м³ мод ашиглах боломжтой. Арчилгааны огтлолт явуулах тохиромжтой нарсан ой тус аймгийн арчилгааны

огтлолтын түүврээр түүгдээгүй бөгөөд орон нутаг зарим нэг залуу дунд насны нарсан ойд бүлгээр ургасан хэсэгт төлөвлөлтийг орон нутгийн ойн анги тогтоож тодорхой хяналтын дор гүйцэтгэх нь шаардлагатай.

Дархан-Уул аймгийн арчилгааны огтлолтын талбай, нөөц

Хүснэгт №68

Арга хэмжээний төрөл	Талбай	Нийт нөөц/ м ³ /	Огтлохнөөц/ м ³ /
Цэвэршүүлэхогтлолт	1251	34610	
Сийрэгжүүлэх огтлолт	1005	45660	
Завсрын огтлолт	290	21640	
Нийт дүн	2546	101910	
Огтлолын эрчим		20%	
Огтлох нөөц м ³	509		20382
Дадалт/жил/	5		
Жилд бэлтгэх хэмжээ	101		4076

* Эх үүсвэр: /Ойн хайгуул ХХК, Ой зохион байгуулалт 2013/

Ойн цэвэрлэгээний огтлолт

Түймэр болон хөнөөлт шавьж өвчинд нэрвэгдсэн ойг цэвэрлэх, ойн экологийн орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр хатсан, цаашид ургах чадваргүй болсон модыг ашиглах зорилгоор цэвэрлэгээний огтлолтыг хийдэг. Цэвэрлэгээний огтлолт нь ойн аж ахуйн чухал арга хэмжээний нэг юм. Цэвэрлэгээний огтлолтыг бүх насны ангийн ойд явуулах боловч болц гүйцсэн, хөгширсөн ойд ихэвчлэн хийдэг. Огтлолтын эрчим нь 10-15% байх боловч ой мод хөнөөлт шавьж, түймэрт хүчтэй нэрвэгдэж их хэмжээгээр модод нь хатсан тохиолдолд эрчмийг нь өндрөөр тогтоож болдог.

Аймгийн хэмжээгээр цэвэрлэгээний огтлолт хийх шаардлагатай ойн талбай, нөөцийг түүврээр түүгдсэнийг нэгтгэж хүснэгтээр харуулав.

Цэвэрлэгээний огтлолын хэмжээ

Хүснэгт №69

Нөөц /мян. м ³ /		Талбай /га/
Хатсан	Унанги	
15935	0	1526

Нийт 1526га талбайгаас 15935м³ хатсан мод авч ашиглах боломжтой байна.

Хатсан болон унанги моднууд нь ойн түймэр гарах, модлогийн хортон шавьж олшрох үндсэн нөхцөл болдог байна. Иймээс тус ойг түймэр болон ойн хөнөөлт шавжаас хамгаалах үндсэн зорилготойгоор цэвэрлэгээний огтлолтыг явуулах шаардлагатай.

Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээ

Дээрхи арчилгаа, цэвэрлэгээний огтлол явуулж байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ нь байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд

зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний доод хязгаарыг хуулинд тодорхой зааж өгсөн байдаг. /хүснэгт 70/

Хүснэгт №70

Д/д	Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь хэмжээний доод хязгаар
1	Байгалийн ургамал ашигласаны төлбөрийн орлого	30 хувь
2	Агнуурын нөөц ашигласаны төлбөрийн орлого	50 хувь
3	Газрын төлбөрийн орлого	30 хувь
4	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласаны төлбөрийн орлого	85 хувь
5	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Дээрхи хүснэгтээс харахад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласаны төлбөрийн орлогын 85 хүртэл хувийг ойг, ой хээрийн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг хангах, удмын санг хамгаалахад зарцуулахад ашиглах боломжтой.

Дархан-Уул аймаг жилд дунджаар 226 га талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажил хийдэг байна. Зураг-32-оос харахад 2003, 2004, 2008, 2009 онуудад 286-467 га талбайд ойжуулалтын ажил хийсэн бөгөөд тус хугацаанд түймэр олонтой гарсан байна. Сүүлийн 3 жилд ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Сүүлийн 10 жилд тус аймгийн хэмжээгээр нийт 2086 га талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлыг хийсэн боловч ойн түймэр, мал, ан амьтан болон бусад хүчин зүйлээс хамаарч ойжуулсан талбайн амьдралт хангалтгүй байна

Дархан-Уул аймгийн хэмжээнд өмнөх жилүүдэд гарсан ойн түймрийн улмаас 716 га, мод огтолсны улмаас 301 га талбай, хөрсний эвдрэлд орсон талбай 96га, ХШӨНТ 15га байгаа нь ойжуулалт нэн шаардлагатай газрын тоонд орж байгаа юм. Ойжих боломжтой газар нутгийг оролцуулан нийтдээ 3979 га ойн талбайг ойжуулах, 7680 га ойн талбайг байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар нөхөн сэргээх, унаган төрхөнд нь оруулах шаардлагатай байна.

Ойг нөхөн сэргээх арга хэмжээний түүврээр нийт аймгийн хэмжээнд, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээг нэгтгэж гаргалаа.

Ойг нөхөн сэргээх арга хэмжээний хүснэгт

Хүснэгт №71

Сумуудаар	Ойжуулалт	Байгалийн сэргэн ургалтанд туслах
Орхон сум	216	1723
Шарын гол	116	484
Дархан сум	189	

Хонгор сум	3458	5473
Нийт	3979	7680

Дээрхи хүснэгтээс харахад байгалийн сэргэн ургалтанд туслах талбай **7680**га, ойжуулалт хийх талбай **3979** га талбайг эзлэн оршиж байна.

Харин унанги болон хатсан модыг ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглах зориулалтаар ашиглаж ойн дагалдах нөөц баялагийг ашигласаны төлбөрийг ойг нөхөн сэргээх ажилд зарцуулах шаардлагатай. 1 жилд ойжуулалт хийх газрын хэмжээг Дархан-Уул аймгийн ойн ангийн хүчин чадал, хүсэлтийн дагуу 250га байхаар авсан болно.

Дархан-Уул аймгийн ойн ангийн гүйцэтгэх ажлын төлөвлөлт

Хүснэгт №72

№	Онууд	1 жилд ойжуулалт хийх талбай	Ойжуулалтын ажил /га/	1 жилд байгалийн сэргэн ургалтанд туслах ажил	Байгалийн сэргэн ургалтанд туслах ажил
1	2016-2018	250	750	200	600
2	2019-2021	250	750	200	600
3	2022-2024	250	750	200	600
4	2025-2027	250	750	200	600
5	2028-2030	250	750	200	600
Нийт			3750		3000

Ойн нөхөрлөлүүдийн хүчээр гүйцэтгэх ажлын төлөвлөлт

Хүснэгт №73

№	Онууд	Ойжуулалт хийх шаардлагатай талбай	Байгалийн сэргэн ургалтад туслах шаардлагатай талбай	1 нөхөрлөлд ногдох ойжуулалт хийх шаардлагатай талбай	1 нөхөрлөлд ногдох Байгалийн сэргэн ургалтад туслах шаардлагатай талбай
	2016-2030	229	4680		
	2016-2030 онд нэмэгдэж болзошгүй	750	1500	14.1	89,5
Нийт		979	6180		

Ойн нөхөрлөлүүд ойн ангитай хамтран ажиллах шаардлагатай бөгөөд ойн анги байнгын онол арга зүйн зөвлөмж өгч ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

V. УСАНСАНГИЙН ГАЗРЫН НӨӨЦ, НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

V.1. Усны сан бүхий газрын өнөөгийн байдал


Дархан-Уул аймаг нь ус зүйн сүлжээ их бөгөөд умард мөсөн далайн ай савд багтана. Голын сүлжээний нягтшил 0,10-0,15 км/км² байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25 мм-ээс дээш юм. Газар нутгийн чийгшил 200-250 мм, ууршилт 200-250 мм жилийн дулаан үеийн ууршилт 600-800 мм гол мөрний усны булингар 100 г/м³-аас дээш. Хатуу урсац жилд 3 м/км² дээш. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10 мм-ээс доош зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 250 мм орчим байдаг. Үерийн аюул гамшиг болон гол мөрөн, булаг шандны ус татарч, улмаар хатаж ширгэх, усны эх үсвэр бохирдох зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, учирсан хөнөөлийг арилгах замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх 2007 онд улсын хэмжээнд усны тооллого явуулж, нийт 956 объект бүртгэгдсэнээс нуур 3, гол горхи-31, булаг 26, худаг 878, үерийн хамгаалалтын далан 8, усан сан 1, услалтын систем 3, цэвэрлэх байгууламж 5 тус тус тоологдсон байна. 2011 онд Дархан-Уул аймагт гадаргын усны тооллого явагдсан байна (Хүснэгт..).

Дархан-Уул аймгийн гадаргын усны тооллого / 2011 он /

Хүснэгт №74

№	Сумдын нэр	Гол горхи		Нуур, тойром		Булаг шанд		Рашаан		Мөстөл мөсөн гол		Услалтын систем		Цэвэрлэх байгууламж		Усан цахилгаан станц
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	
1	Дархан сум	3	3	-	-	2	2	-	-	-	-	-	-	1	1	-
2	Орхон сум	4	4	2	2	5	3	-	-	-	-	2	2	1	1	-
3	Хонгор сум	15	15	-	-	24	24			-	-	-	-	2	1	-
4	Шарын гол сум	4	3	-	-	-	-			-	-	-	-	1	1	-
Бүгд		26	25	2	2	31	29	-	-	-	-	2	2	5	4	-

Дээрхи хүснэгтээс харахад 2011 онд явагдсан усны тооллогоор Дархан-Уул аймгийн хэмжээнд 26 гол, горхи тоологдсоноос 1 ширгэсэн, 31 булаг шандаас 2 ширгэсэн, 431 худаг, 2 нуур тоологдсон байна. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр 2008-2009 онд 10 булаг, шандыг тохижуулсан байна.



Зураг №39. Усны сүлжээний зураг

V.2. Усны сан бүхий газрын төлөвлөлт

V.2.1. Усны менежментэд баримтлах үндсэн зарчим

Хот, тосгон, бусад суурины газрын хувьд усны сан бүхий газар, усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах зорилт нэгдмэлээр шийдэгдэж байж хэвийн оршин тогтнох нөхцөлтэй байдаг. Иймээс Дархан-Уул аймгийн гадаргын болон гүний усны нөөцийн байгалийн тэнцэл, усны чанарыг газар ашиглалтаар дамжуулан хангахын тулд усны сан бүхий газрыг ялангуяа **усны эх газар, усны эрэг хөвөө газар, усархаг чийглэг газрыг хамгаалахад чиглэсэн горимын бүсүүд буй болгож ашиглалтын горимыг одоогийнхоос эрс өөрчлөхөөр төлөвлөв.**

Дархан-Уул аймгийн төвлөрсөн усан хангамжийн гүний усний тэжээлийн нөөцийн гол талбарыг ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай бохирдуулагч бодисоос хамгаалах, гүний ус байгалийн өөрийн горимоор нөхөн сэргээгдэх нөхцөлийг хангахын тулд газрын гадаргуугийн төрх байдлыг хөндөхгүйгээр хадгалах зорилгоор усны хамгаалалтын бүсүүдийг тогтоож, ашиглалтын горимыг тодорхойлж ус өөрөө цэвэрших нөхцлийг хангах зорилгоор хамгаалалтын бүсэд оруулав.

“Усны тухай” хуулийн 24.2 дахь заалтын дагуу Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлах шаардлага зүй ёсоор гарч байна.

Ундны ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн тэжээлийн муж болон дэвсгэр талбайг бүхэлд нь ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд оруулж барилга байгууламж барих, ашигт малтмал хайх, олборлох зориулалтааргазар олгохыг хатуу хориглох санал тавьж байна.

V.2.2. Усны сан бүхий газрын менежментийн бүсүүд, ашиглалт, хамгаалалтын горим

Ундны усны эх, ундарга, нөөцийг зохистой ашиглах, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зааг, бүсийн дэглэмийг тогтоох шаардлагатай байдаг. Иймээс Дархан-Уул аймгийн усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон усны сан бүхий газрын менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Ундны усны ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүс-9221га

Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагатай байдаг. Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдөж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглодог. Улсын болон аймгийн зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн

хязгаарлалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээгдлийн бүс болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хурах талбайг хамруулан тогтоох шаардлагатай байдаг. Иймээс ундны усны ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоохдоо Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан удирдамжийг удирдлага болгон хийж гүйцэтгэсэн. Ундны усны ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтооходоо хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сангийн эргээс 200 метр, гадна орших усны сангийн эргээс 100 метрээр эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоосон.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

1. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.
 - Эх үүсвэрийг ашиглах зориулалттай барилга байгууламжийг ариутгах татуургын системд холбоно. Хэрэв боломжгүй бол бохир усны цооног, бие засах газрыг бүсийн гадна байрлуулна;
 - Ус хангамжийн барилга байгууламжид өргөтгөх, засварлах ажил хийхдээ байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын байгууллагын баталсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэнэ;
 - Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн эргэн тойрныг хашиж хамгаалан байнгын харуул хамгаалалттай байлгах бөгөөд худаг, усан сангийн таг, салхивчийг битүүмжлэн хялбар нээх, эвдэх боломжгүй болгоно;
 - Бүсийн талбайг тогтмол цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж, хөнөөлт шавьж мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар механик аргаар хийлгэнэ;
 - Усны эх үүсвэрийн гидрогеологийн нөхцлөөс шалтгаалан эрүүл ахуйн бүсэд нэмэлт арга хэмжээ авч болно.
2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
 - Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
 - Цэвэршүүлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
 - Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
 - Унд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
 - Төвлөрсөн ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээтэй газар унд ахуйн зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
 - Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;

- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- Автотээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;
- Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;

Усны хамгаалалтын бүс-4161га

Усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор усны сан бүхий газар хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай байдаг. Дархан-Уул аймаг нь Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг БОАЖСайдын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу усны газартай хамтран усан сан, голын хамгаалалтын бүсийн заагийг тогтоох ажлыг зохион байгуулан ажиллаж ирсэн байна. Дээрх ажлын хүрээнд 4 сумын нутаг дэвсгэрт байгаа усан сан, голын хамгаалалтын бүсийг 1000 м-ээр тогтоож сумдын засаг даргын захирамж гарган ажиллаж иржээ. Иймээс усны хамгаалалтын бүсийг тогтоохдоо Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан удирдамжийг удирдлага болгон хийж гүйцэтгэсэн. Усны хамгаалалтын бүсийг тогтоохдоо хот суурин газрын нутаг дэвсгэр дэх голын эргээс 1000 метр, гадна орших голын эргээс 200 метр, булаг шандын эхийн эргэн тойрноос 50 метр, нуур усан сангийн эргээс 100 метрээр хамгаалалтын бүсийг тогтоосон.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

1. Усны хамгаалалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.
 - Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн байгууламж барьж ашиглах;
 - Гадаргын усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглах тохиолдолд гадаргын усыг цэвэршүүлэх байгууламж барих;
 - Зураг төсөл нь батлагдаж, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн усны барилга байгууламж /үерийн хамгаалалт, тохируулгын байгууламж, усан цахилгаан станц/ барих;
 - Ариутгах татуургын байгууламжаас бусад иргэний болон дэд бүтцийн барилга байгууламж /гүүр, зам, усан зогсоол, цэвэр усны шугам сүлжээ, цахилгаан дамжуулах шугам/ барих;
 - Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гольфоос бусад спорт тоглоомын талбай байгуулах, мод бут сөөг тарих;
 - Хяналт-шинжилгээний цооног гаргах, хяналт-шинжилгээ явуулах.

2. Усны хамгаалалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Түгээмэл тархалттай ашигт малтмал хайх, олборлох;
- Мод бут огтлох;
- Хаягдал бохир усыг цэвэршүүлэх байгууламжгүй буюу ариутгах татуургад холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах;
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах, агуулах;
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах;
- Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;
- Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах.

Энгийн хамгаалалтын бүсэд түгээмэл бус тархацтай ашигт малтмал олборлох асуудлыг тухайн усны сан бүхий газрын усны нөөц, горим, гидрогеологийн онцлог нөхцөл, олборлох технологи зэргийг харгалзан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн тусгайлан шийдвэрлэж болдог байна.

Усны эх газрын хамгаалалтын бүс -11623га

Гол, мөрний усжих талбайн дээд эхийн ой болон ус намгархаг газрууд хамаарна.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

Бүсэд суурьшлын болон ашигт малтмал хайх, олборлох, хүнд болон химийн үйлдвэр байгуулах, газар тариалан эрхлэх, бусад барилга байгууламжийн зориулалтааргазар олгохыг хатуу хориглох. Зөвхөн байгаль хамгаалах, ойн аж ахуй, жимс жимсгэнэ, бэлчээр, хадлангийн зориулалтаар ашиглуулах.

Усан хангамжийн тэжээлийн муж-2825га


Ус хангамжийн газрын доорхи усны эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоохдоо тухайн эх үүсвэрийн усны орд газрын усны хуримтлалыг бий болгож байгаа сав газрыг бүхэлд нь хамруулах буюу усны хагалбарын хилээр хязгаарлана.Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоох шаардлагатай байдаг. Хэрвээ төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашиглавал түүний эргээс 200 метрээс доошгүй зайд, урсгал усны хувьд дээд талд 50к м-ээс доошгүй, доод талд 500 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.

Дархан-Уул аймаг нь усны нөөц, чанарын мэдээллийг үндэслэн усны нөөц хомсдох, бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн аясаар нөхөн сэргэгдэх чадавхийг дэмжих, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах зорилгоор Герман улсын “МОМО” төсөл 2006-2009 онуудад Дархан сумын ус хангамжийн эх үүсвэр, инженерийн шугам сүлжээний өнөөгийн байдал, бохир усны цэвэрлэгээ, Хараа голын усны нөөц зэрэг чиглэлүүдийн судалгааны ажлууд хийгдэж, 2 төрлийн загвар модель боловсруулагдсан Газрын доорх усны ажиглалт хийх гүний усны цооног болон шинээр байгуулах харуулын судалгааг гаргаж, Хараа голын дагуу гүний усны 5 цооног, Шарын гол суманд 2 цооног, нийт 7 гүний усны цооног гаргах шаардлагатай гэж үзжээ. 2008 онд Хонгор суманд 680.0 сая төгрөгийн өртгөөр 3.5км урт 100 мм-ын хос шугамтай 100 м³ багтаамжтай усан хангамжийн байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан байна.

Монгол Улс болон Япон Улсын Засгийн газрын хамтарсан нот бичигт гарын үсэг зурагдсанаар Дархан-Уул аймагт 2009-2011 онуудад Япон Улсын буцалтгүй тусламжын хүрээнд ЖАЙКА Олон Улсын байгууллагатай хамтран “ДАРХАН ХОТЫН УСАН ХАНГАМЖИЙН БАЙГУУЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ” төсөл 2009 онд хэрэгжиж эхэлсэн. Уг төслийн хүрээнд Япон улсад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт японы “НИШИЗАВА-ОНАИКА ХАМТАРСАН НЭГДЭЛ” шалгаран төслийн зөвлөх баг “Токио инженеринг”, Захиалагч “Дархан Ус суваг” ХХК-тай хамтарсан гэрээг байгуулан 1 дугаар өргөгч станцын шинэчлэлт, 5, 6 дугаар багийн цэвэр ус дамжуулах шугам сүлжээ, ус түгээх 12 байр, 2 дугаар өргөгчийн техник, технологийн ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.

БАРИМТЛАХ ЧИГ БОДЛОГО

Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон түүний тэжээгдлийн мужид усны нөөцийн өөрчлөлт, горим, чанарын талаархи мэдээ гарган авах зорилгоор байнгын хяналт-шинжилгээ хийнэ. Улсын нэгдсэн хяналт-шинжилгээний сүлжээнээс гадна томоохон хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалтын /ус хангагч/ байгууллага нь тухайн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон түүний тэжээгдлийн мужид хяналт-шинжилгээ хийж дүнг Усны газарт тогтоосон хугацаанд хүргүүлэх ёстой байдаг.



Зураг №40. Усны сан бүхий газрын менежментийн бүсүүд

VI.ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙНТӨЛӨВЛӨЛТ

VI.1 Улсын тусгай хамгаалалтай газар нутаг

Улсын тусгай хамгаалалтад шинээр оруулах шаардлагатай газар байхгүй

VI.2Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

VI.2.1 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын харилцаа нь нийт газрын харилцааны салшгүй хэсэг тул юуны өмнө Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалттай байна. Монгол Улсын Үндсэн хуулинд: “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан нь энэ төрлийн харилцааны эрх зүйн эх сурвалж болдог байна. Түүнчлэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3-р зүйлийн 2-т зааснаар “аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно” гэж заасан нь орон нутгийн тусгай хамгаалалттай газрын харилцааг бие даан хөгжих эрх зүйн үндэсийг тавьсан байна. Тухайлбал орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь нутаг дэвсгэр, газар гэдэг утгаараа Монгол Улсын Газрын тухай хуулиар зохицуулагддаг бол хамгаалалттай нутаг дэвсгэр гэдэг талаасаа бол Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай журам зэргээр зохицуулагддаг байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь аль нэг субъектийн тодорхой ашиг сонирхолд бус, харин тухайн орон нутгийн нийтийн ашиг сонирхолд үйлчилж байдаг онцлогтой. Нэгэнт нийтийн ашиг сонирхолд үйлчилж байгаа тул заавал эрх зүйн тусгай дэглэм тогтоож, нарийвчлан зохицуулах шаардлагатай байдаг. Одоогийн байдлаар манай улсад орон нутгийн тусгай хамгаалалттай газрын харилцаанд шууд хамааралтай ганц журам (Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай журам), дам хамааралтай хэдэн хууль (Монгол улсын Газрын тухай хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль) зэргээр зохицуулж байна. Энэ төрлийн газрын эрх зүйн харилцааны объект нь орон нутгийн хамгаалалтанд авсан газар юм. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах Байгаль орчны сайдын 2000 оны 07 дугаар тушаалын журмаар “Орон нутгийн хамгаалалттай газар” гэж тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авсан газрыг хэлдэг байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь газрын нэгдмэл сангийн ангилалаар тусгай хэрэгцээний газрын орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамрагдах бөгөөд дотор нь засаг захиргааны нэгжээр аймаг нийслэлийн, сум дүүргийн гэж ангилна.

Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБ-ынхөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр БОНХЯ дээр хэрэгжиж буй “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн хүрээнд “Орон нутгийн хамгаалалттай газрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэх” ажлын хүрээнд “Геоботаник” ХХК орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан болон авахаар төлөвлөж буй газар нутгийн байршил, хил заагийг тодорхойлж мэдээллийн баазыг байгуулсан байна. Дархан уул аймаг нь Улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй бөгөөд орон нутгийн хамгаалалтанд газруудыг доорхи хүснэгтэд харууллаа.


Дархан-Уул аймгийн орон нутгийн хамгаалалттай газар нутаг

Хүснэгт №75

Сумын нэр	Газрын нэр	Зориулалт	Зэрэглэл
Шарын гол	Шарын хөндий	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Хонгор, Шарын го	Дархан-Уул хайрхан	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг
Шарын гол	Буянт, Хар морьт	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Дархан	Найрамдал	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг
Шарын гол	Дархан хөтөл даваа	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Шарын гол	Олон хөтөл даваа	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Шарын гол	Цагаан хөтөл	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Шарын гол	Шар хөндий	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Шарын гол	Бурхант	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Хонгор	Хустын булаг	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум
Хонгор	Мөөл уул	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум

Дээрхи орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, зураглахдаа орон нутгийн саналыг авч давхцалтай болон зөрчилтэй талбайнуудын зөрчлийг арилгаж зурагласан болно.

Дархан, Хонгор сумууд Хараа голын дагуух газрын сумын тусгай хэрэгцээнд хамруулсныг нэмж зурагт оруулав.



Зураг №41. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зураг

VI.2.2. Шинээр орон нутгийн тусгай хамгаалалтад авах газар нутаг


Орон нутгийн тусгай хамгаалалт түүн дотор аймгийн тусгай хамгаалалтад хамруулахаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас санал өгсөн 1 газар, сумын тусгай хэрэгцээнд хамруулахаар сумаас санал өгсөн 2 газар байгаа бөгөөд аймгийн тусгай хамгаалалтад Хонгор сумын нутагт хамаарах Мөөл уул орчмын газар юм гэхдээ Аймгийн ИТХ-н 2015 оны 11 сарын 26-ны өдрийн 79-р тогтоолоор Мөөл уулыг Аймгийн тухай хамгаалалтад авсан байна. Аймгийн тусгай хамгаалалтат шинээр авсан Мөөл уул нь “Монголын нууц товчоо”-нд дурдсанаар Тэмүжин, Жамух хоёрын тулалдсан “Хүйтэн уул”-ын тулаан болсон газар төдийгүй одоогийн нэрээр Хүйтэн уул, Хүйтний гол нэрээрээ байгаа тухайн цаг үед Тайчуудын нутаглаж байсан бол хожуу үеийн дурсгал “Бичигт хад”-ны бичээст дурсгал энэхүү Хүйтэн уулын савд хадгалагдан үлдсэн газар юм. Үүнээс гадна Аймгийн ГЗБЕТ-ий ажлыг хэлэлцүүлэх, хүлээлгэн өгөх үе шатанд Аймгийн БОНХ-н газраас Мөөл уул орчмын зарим газар нутаг буюу Сонгино уул, Их нарст уул, Шивэрт, Өгсөө уул, Хүйтний голын эх бичигт хад зэрэг газруудыг нэмж тусгай хэрэгцээнд авах шаардлагатай гэсэн санал өгсөн бөгөөд санал болгож буй хил зааг тодорхойгүй тул төлөвлөлтийн зурагт оруулаагүй. Цаашид төлөвлөлтийн үе шатуудад хил заагийг нарийвчлан тогтоож тусгай хамгаалалтад авах боломжтой.

Санал болгож буй газрын хил зааг дахь газрын нэгдмэл сангийн бүтэцийг авч үзвэл доорх байдалтай байна.


Аймгийн тусгай хамгаалалтад авах газрын нэгдмэл сангийн бүтэц

Хүснэгт №76

Газрын нэр	Сумын нэр	Одоогийн статус	Бэлчээр	Өвөл жөө хавар жааны газар	Тариалангийн газар	Зам, шугам сүлжээний газар	Гол, мөрөн, нуур	Ойн сан бүхий газар	Дүн
Цагаан нуур	Орхон		58.27				14.17		72.44
Ерөө гол	Орхон		712.09	4.19		10.16		76.90	799.14



Зураг №42. Аймгийн тусгай хамгаалалтад авахаар БОНХ-н газрын санал өгсөн газрын байршил



Зураг №43. Сумын тусгай хамгаалалтад авах газрын байршил

ТӨГСӨВ

ТАЛАРХАЛ

Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хээрийн судалгааны үе шатанд сумдын Засаг дарга, ИТХ, ЗДТГ-н дарга, Газрын даамал, Байгаль орчны мэргэжилтэн, ХАА-н газрын мэргэжилтэн зэрэг албан тушаалтангууд мөн иргэдийн төлөөлөлүүдтэй хамтран ажилласан бөгөөд Аймгийн түвшинд чиглэл бүрийн газар хэлтэсүүдтэй нягт холбогдон ажиллаж саналыг бичгээр болон аман хэлбэрээр авч ажиллаж байсан.

Уг ажлыг гүйцэтгэхэд идэвхитэй хамтран ажиллаж санал, зөвлөмжөө өгсөн бүх хүмүүстээ болон Дархан-Уул аймгийн Засаг дарга А.Эрдэнэбат, Хөгжлийн бодлогын хэлтэсийн дараг Д.Баасанжав, Хөгжлийн бодлогийн хэлтэсийн мэргэжилтэнгүүд болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хамт олонд онцгойлон талархал илэрхийлж байна.

Ашигласан материалын жагсаалт

№	Хөтөлбөрийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хэрэгжүүлэх хугацаа
1	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” УИХ 2008 оны 01 сарын 31, 12-р тогтоол	
2	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	
3	Төрөөс хvнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого 2009 оны 7-р сарын 15	
4	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 39 дүгээр тогтоол	
5	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр УИХ-н тогтоол 2010 оны 06 сарын 25 өдөр	
6	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол	
7	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УИХ-н 2001 оны 57 дугаар тогтоол	
8	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 45 дугаар тогтоол	
9	Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр /засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 120-р тогтоол/ Шинэчлэлийн засгийн газар, Яамдын үйл ажиллагааны төлөвлөгөө; Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2012-2016 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	2012-2016
10	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоол	1997-2030
11	“Сүү” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2006 оны 239 дүгээр тогтоол	2006-2020
12	Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоол	2001-2020
13	“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2008.07.08 дугаар 288	2008-2016
14	“Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2009.02.04-ний 32 дугаар тогтоол	2009-2016
15	“Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” Засгийн газрын 2009.09.30-ны 299 дүгээр тогтоол	2009-2016
16	“Ариун цэврийн байгууламжийг сайжруулах” хөтөлбөр /Нийтийн бохирын шугам, цооног, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламж/ Засгийн газрын 2006.10.11-ний 246 дугаар тогтоол	2006-2015
17	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр Засгийн газрын 2003.06.24-ний 160 дугаар тогтоол	2003-2015
18	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 103 дугаар тогтоол	1998-2020
19	“Малын чанар сайжруулах” хөтөлбөр. Засгийн газрын 2006.04.26-ны 93 дугаар тогтоол	2006-2015
20	“Малын тэжээл” хөтөлбөр Засгийн газрын 2007.11.07-ны 283 дугаар тогтоол	2008-2015
21	“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” үндэсний хөтөлбөр УИХ-ын 1997 оны 106 дугаар тогт	2000-2021
22	Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол	1998-2021

23	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1996 оны 163 дугаар тогтоол	1996-2016
24	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр УИХ-ын 1998 оны 29 дугаар тогтоол	1998-2015
25	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2003.06.04-ний 141 дүгээр тогтоол	2003-2012
26	Ойн тухай үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол.	2001-2015
27	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1999.02.10-ны 25 дугаар тогтоол	1999-2015
28	“Чанарын болон байгаль орчны удирдлага /менежмент/-ийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2002.07.08-ны 146 дугаар тогтоол	2002-2016
29	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2000 оны 120 дугаар тогтоол	2000-2015
30	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2008 оны 267 дугаар тогтоол	2008-2015
31	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2005.03.09-ний 44 дүгээр тогтоол	2005-2025
32	“Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах” хөтөлбөр Засгийн газрын 2006. 12.20-ний 309 дүгээр тогтоол	2010-2015
33	“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” Засгийн газрын 2008.02.27-ны 71 дүгээр тогтоол	2008-2015
34	“Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр” Засгийн газрын 2008.03.05-ны 84 дүгээр тогтоол	2008-2015
35	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2008.02.27-ны 78 дугаар тогтоол	2008-2012
36	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	2012 он
37	Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021
38	Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2013-2025
39	2003 онд батлагдсан УГЗБЕ төлөвлөгөө	2003-2023
40	Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	2011-2025
41	Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого	2010-2021
42	Дархан-Уул аймгийн ХАА-н салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого	2009-2021
43	Монгол улсын статистикийн эмхэтгэл	2014
44	Дархан хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	2014
45	Орхон сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	2014
46	Шарын гол сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	2013
47	Дархан-Уул аймгийн ойн тооллого, зохион байгуулалтын тайлан зураг	2013
48	Дархан-Уул аймгийн байгаль орчны төлөв байдлын нарийвчилсан судалгаа	2010
49	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм, стандартууд	